



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ



МОНГОЛЫН
КРИМИНОЛОГИЧДЫН
ХОЛБОО

ХОХИРЛЫН ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦОО

МОНГОЛ УЛСАД ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРЛЫГ
ҮНЭЛЖ, ТОГТООЖ, НӨХӨН ТӨЛҮҮЛЖ БУЙ
НӨХЦӨЛ БАЙДАЛ

ЦУВРАЛ СУДАЛГАА №1



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ



МОНГОЛЫН
КРИМИНОЛОГИЧДЫН
ХОЛБОО

ХОХИРЛЫН ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦОО

МОНГОЛ УЛСАД ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРЛЫГ
ҮНЭЛЖ, ТОГТООЖ, НӨХӨН ТӨЛҮҮЛЖ БУЙ
НӨХЦӨЛ БАЙДАЛ

ЦУВРАЛ СУДАЛГАА №1

Улаанбаатар хот
2020 он

ННА 67.408
ДАА 345
Х-514

Судалгааны багийн ахлагч:

Г.ЭРДЭНЭБАТ, Монголын Криминологичдын холбооны ерөнхийлөгч

Зөвлөх:

Ч.НЯМСҮРЭН, ДХИС-ийн Судлаачийн хөгжлийн төвийн эрхлэгч
Хууль зүйн доктор, профессор

Шүүмжлэгч:

М.ВАНЧИГМАА, ҮБХИС-ийн Аюулгүй байдлын дээд сургуулийн
Нийгэм хүмүүнлэгийн тэнхимийн ахлах багш, өмгөөлөгч, судлаач

Судлаачид:

Б.МӨНХДОРЖ, Хууль зүйн доктор, ДХИС-ийн Боловсрол судлалын төвийн
эрхлэгч, Хууль зүйн доктор (Ph.D)

Н.ТУЯА, Хуульчдын холбооны Сургалтын хорооны гишүүн, Хууль зүйн доктор,
Монголын Криминологичидын холбооны удирдах зөвлөлийн гишүүн

Г.ОЮУНБОЛД, Хууль зүйн магистр, Монголын Криминологичидын холбооны
Сургалт, судалгаа эрхэлсэн дэд захирал, Хууль зүйн магистр

О.МӨНХЦЭЦЭГ, Судлаач, Хууль зүйн магистр

А.ЕРКЕГҮЛ, Баян-Өлгий аймгийн прокурорын газрын ахлах прокурор,
Хууль цаазын итгэмжит зөвлөх, Хууль зүйн магистр, докторант

Б.АРИУНТУЯА, СХД-ийн шүүхийн шүүгчийн туслах, судлаач

Б.АРИУНЖАРГАЛ, ХЗҮХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, судлаач

Судалгааны хүрээнд гарсан дүгнэлт, санал нь зөвхөн судлаачдын үзэл бодол бөгөөд
Нээлттэй Нийгэм Форум болон бусад байгууллагын албан ёсны байр суурийг
илэрхийлэхгүй болно.

© Нээлттэй Нийгэм Форум, 2020

“Би Си Ай” ХХК-д эхийг бэлтгэж, хэвлэв.

ISBN 978-9919-9678-1-9

ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ	7
ӨМНӨТГӨЛ.....	8
НЭГ. УДИРТГАЛ.....	10
1.1. Судалгааны үндэслэл, шаардлага.....	10
1.2. Судалгааны зорилго, зорилт.....	11
1.3. Сэдвийн судлагдсан байдлын тойм.....	12
1.4 Судалгааны арга зүй ба хамрах хүрээ.....	14
ХОЁР. СУДАЛГААНЫ ТАЙЛАН.....	20
2.1. Эрх зүйн орчин.....	20
2.2. Монгол улс дахь гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийн нөхцөл байдал.....	27
2.3. Тодорхой төрлийн гэмт хэрэг тус бүрийн хохирол нөхөн төлүүлэлтийн талаарх тоон мэдээлэл, статистик	34
2.4. Гэмт хэргийн хохирол, хор уршгийг тогтоож, нөхөн төлүүлсэн байдалд хийсэн дүн шинжилгээ.....	71
ДҮГНЭЛТ	88
САНАЛ, ЗӨВЛӨМЖ	91
НОМ ЗҮЙ	93
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	
Хүснэгт 1.1. Кейс судалгаа хийсэн эрүүгийн гэмт хэргийн тоон мэдээлэл (2017 ба 2018 он).....	16
Хүснэгт 2.1. 2017 болон 2018 онд гэмт хэргийн улмаас учирсан хохирлын талаарх тоон мэдээ (он тус бүрээр).....	29
Хүснэгт 2.2. Гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн талаарх тоон мэдээ	30
Хүснэгт 2.3. 2017 болон 2018 онд гэмт хэргийн улмаас эрүүл мэндээрээ хохирсон нөхцөл байдлын талаарх тоон мэдээлэл	30

Хүснэгт 2.4. Гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн хохирлын талаарх тоон мэдээ	32
Хүснэгт 2.5. Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлт.....	36
Хүснэгт 2.6. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлт.....	37
Хүснэгт 2.7. Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлт.....	41
Хүснэгт 2.8. Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлт.....	43
Хүснэгт 2.9. Эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлт.....	45
Хүснэгт 2.10. “Хүүхдийн эсрэг гэмт хэрэг” бүлгийн хохирол нөхөн төлүүлэлт.....	47
Хүснэгт 2.11. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлт.....	49
Хүснэгт 2.12. Эдийн засгийн гэмт хэргийн хохирол нөхөн төлөгдсөн нөхцөл байдал.....	52
Хүснэгт 2.13. Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлт	54
Хүснэгт 2.14. Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлт.....	57
Хүснэгт 2.15. “Авлигын гэмт хэрэг” бүлгийн хохирол нөхөн төлүүлэлт.....	59
Хүснэгт 2.16. Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлт.....	61
Хүснэгт 2.17. “Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг” бүлгийн хохирол нөхөн төлөгдсөн нөхцөл байдал.....	63
Хүснэгт 2.18. “Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг” бүлгийн хохирол нөхөн төлөгдсөн нөхцөл байдал.....	65
Хүснэгт 2.19. “Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг” бүлгийн хохирол нөхөн төлөгдсөн нөхцөл байдал	67
Хүснэгт 2.20. “Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг” бүлгийн хохирол нөхөн төлөгдсөн нөхцөл байдал	69
Хүснэгт 2.21. “Хавтаст хэргийн судалгаа”-ны хүрээнд судалсан хэргийн тоо.....	71
Хүснэгт 2.22. Хохирлын үнэлгээ хийх хүснэгт.....	72

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 2.1. Гэмт хэргийн улмаас эрүүл мэндээрээ хохирсон иргэдийн талаарх тоон мэдээ	31
График 2.2. Гэмт хэргийн улмаас эрүүл мэндээрээ хохирсон иргэдийн гэмтлийн зэрэг	31
График 2.3. Гэмт хэргийн улмаас эрүүл мэндээрээ хохирсон иргэдийн насны байдал	32
График 2.4. Гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн хохирол, нөхөн төлүүлэлт (сая төгрөгөөр)	33
График 2.5. Гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн хохирол, битүүмжилсэн эд хөрөнгө (сая төгрөгөөр).....	33
График 2.6. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол (2017-2018 онд сая.төг).....	84

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
МУҮХ	Монгол Улсын Үндсэн хууль
ЭХХШтХ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
ИХ	Иргэний хууль
ЦЕГ	Цагдаагийн Ерөнхий газар
УЕПГ	Улсын Ерөнхий Прокурорын газар
ШЕЗ	Шүүхийн Ерөнхий Зөвлөл
ХЭҮК	Хүний эрхийн Үндэсний комисс
ЭБШХ	Эрүүгийн байцаан шийтгэх хууль

ӨМНӨХ ҮГ

Манай улсад 2012 оноос эхэлсэн Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн үндсэн чиглэлийн нэг нь хохирогч хамгаалах, хохирол барагдуулах тогтолцоо бүрдүүлж хэрэгжүүлэх явдал билээ. Гэмт хэргийн хохирол, хор уршгийг шударгаар барагдуулах нь Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрх төдийгүй, нийгмийн эмзэг бүлгийн хохирогчдын эрхийг хамгаалах, гэмт хэрэгтэй үр нөлөөтэй тэмцэхэд чухал нөлөөтэй. Нээлттэй Нийгэм Форум нь Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн энэхүү чухал зорилтын хэрэгжилтийг судлах саналыг Монголын криминологчдын холбооны судлаачдад тавьсан юм.

Ийнхүү хохирлын үндэсний тогтолцоог үнэлэх чиглэлээр хийгдэж буй анхны судалгаа болох “Монгол Улсад гэмт хэргийн хохирлыг үнэлж, тогтоож, нөхөн төлүүлж буй нөхцөл байдал”-ын судалгааг уншигч Танд хүргэж байгаадаа баяртай байна. Тус судалгаа нь гэмт хэргийн хохирол, хор уршгийг барагдуулж буй өнөөгийн практик, тулгамдаж буй асуудлыг шинэ эрүүгийн хууль тогтоомжийн хүрээнд судалснаараа өндөр ач холбогдолтой.

Цаашид бид энэ сэдвийн хүрээнд илүү нарийвчилсан судалгаа, шинжилгээ хийж уншигчдад хүргэхээр ажиллаж байгаа бөгөөд бидний судалгааны ажилд Таны өгөх санал, шүүмж онцгой үнэ цэнтэй байх болно.

Нээлттэй Нийгэм Форум нь манай улсад өрнөж буй Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийг бодлогын судалгаа, мониторингоор дэмжихийг зорьж ирснийг энэ дашрамд дурдахад таатай байна.

ННФ-ын Гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал

ӨМНӨТГӨЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн арван зургаадугаар зүйлийн 14 дэх хэсэгт “...бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх” эрхийг баталгаажуулсан билээ. Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрхийг хэрэгжүүлэх үүднээс Монгол Улсын Эрүүгийн хуулийн 2.5 дугаар зүйлд гэмт хэргийн хохирол, хор уршгийн ялгааг нарийвчлан тодорхойлсон нь оновчтой болсон төдийгүй, эрүүгийн эрх зүйн онол, хууль зүйн практикт ч чухал ач холбогдолтой юм. Нийгмийн хүсээгүй үзэгдэл, үр дагавар болох гэмт хэрэг, түүнээс учирсан эд хөрөнгийн болон бие махбод, сэтгэл санааны хохирол өнөөдөр зөвхөн гэмт хэргийн хохирогч төдийгүй улс, нийгэм, эдийн засагт учруулах хор уршиг нь ч улам ноцтой болж байна. Монголын Криминологичдын холбоо ТББ нь Нээлттэй Нийгэм Форумын захиалгаар хийж гүйцэтгэсэн “Монгол Улсад гэмт хэргийн хохирлыг үнэлж, тогтоож, нөхөн төлүүлж буй нөхцөл байдал”-ын судалгааны тайланг Та бүхэнд толилуулж байна. Энэ нь шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийг дагаж мөрдөж эхэлснээс хойших хохирол нөхөн төлүүлэлтийн нөхцөл байдлын талаар хийгдэж буй анхны бүрэн хэмжээний судалгаа мөн.

Энэхүү судалгааны ач холбогдол нь Монгол Улсын хэмжээнд эрүүгийн хэргийн хэрэг бүртгэх, мөрдөн шалгах, яллах, шүүн таслах ажиллагааны явцад гэмт хэргийн хохирол, хор уршгийг тогтоох, үнэлэх, хохирол, хор уршгийн мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх хэмжээг тодорхойлох, түүнийг нөхөн төлүүлэх эрх зүйн орчин болон шүүхийн практикийг судлах, хохирогчийн эрх ашгийг баталгаатай хангаж хадгалахуйц эрх зүйн орчин бүрдүүлэх боломжийг судалж, санал дэвшүүлсэнд оршино.

2019 онд баталж 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 22 дугаар зүйлд гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх байгууллага, тэдгээрийн албан ёсны тоо мэдээнээс хараат бусаар

гэмт хэрэг, зөрчлийн бодит нөхцөл байдлыг тогтоох, гэмт хэрэг, зөрчлийн нийгэмд үзүүлж байгаа нөлөөлөл, хор уршгийг тогтоох зорилгоор “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэгч байгууллага гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлын судалгааг хоёр жил тутамд, гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгааг гурван жил тутамд улсын хэмжээнд, эсхүл тодорхой нутаг дэвсгэрийн хэмжээнд, эсхүл тодорхой гэмт хэрэг, зөрчлийн төрлөөр олон нийтийн дунд зохион байгуулна” гэж заасан. Олон нийтийн дунд зохион байгуулах энэхүү судалгаа нь 2010 онд НҮБ-ын мансууруулах бодис, гэмт явдлын талаарх хорооноос баталсан “Гэмт явдалд хохирох явдлын судалгааны удирдамж” (*Manual on victimization surveys*)-ийн дагуу явагдах бүрэн боломжтой.

Энэхүү судалгаа дээр дурдсан судалгааны өмнөтгөл болох нь дамжиггүй. Цаашид Монголын криминологичдын холбоо ТББ нь “Гадаад улс орнуудад гэмт хэргийн хохирлыг тооцох, үнэлэх, нөхөн төлбөр олгох тогтолцоо, эрх зүйн зохицуулалт, сайн туршлага”-ыг судалж, өөрийн орны нөхцөлд нутагшуулах, энэ чиглэлээр хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал, дүгнэлт боловсруулах ажлыг үргэлжлүүлэн хийхээр төлөвлөж байгаа нь туйлын сайшаалтай. Судалгаа нь хууль тогтоогч, хэрэглэгч, хэрэгжүүлэгч төдийгүй, хууль зүйн эрдэмтэн судлаач, оюутнуудын ширээний ном болно гэдэгт итгэлтэй байна.

Сайн үйлс дэлгэрэх болтугай.

Хууль зүйн ухааны доктор, профессор Ч.Нямсүрэн

НЭГ. УДИРТГАЛ

1.1. СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ, ШААРДЛАГА

Хүний зөрчигдсөн эрхийг сэргээх асуудал нь эрх зүйн харилцаанд юу юунаас илүү чухал зүйл билээ. Хэдий тийм боловч өнөөдөр хүн, хуулийн этгээд гэмт хэргийн улмаас учирсан хохирлоо барагдуулж, хор уршгаа нөхөн төлүүлж чадахгүй байсаар байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт болон Монгол Улсын Үндсэн хууль (МУҮХ)-д “бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрх”-ийг хуульчилсан бөгөөд уг баримт бичгүүдэд “төр иргэнийхээ эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг нь сэргээх үүргийг хариуцах” тухай, МУҮХ-ийн арван зургаадугаар зүйлийн 14 дэх хэсэгт иргэнд “...бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхийг...”, арван есдүгээр зүйлд төрийн “хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг” тус тус заасныг хэрэгжүүлэх зорилгоор Эрүүгийн хуулийг 2015 онд, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (ЭХХШтХ)-ийг 2017 онд тус тус шинэчлэн баталж, мөрдөөд даруй гурван жил өнгөрөөд байхад гэмт хэргийн хохирлыг тогтоох, үнэлэх ажиллагаа одоо ч хуучин арга барилаар явагдаж, хохирол нөхөн төлүүлэх, хохирогчийн эрхийг нөхөн сэргээх явдал хангалтгүй байна гэх шүүмжлэл хэргийн оролцогч талуудаас гарсаар байна.

Монгол Улсын эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд гэмт хэргийн хохирлын талаарх уламжлалт ухагдахууныг өөрчилж, гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг тогтоох, тодорхойлох, мөнгөн дүнгээр илэрхийлж нөхөн төлүүлэх

материаллаг болон процессын эрх зүйн шинэ орчин бүрдсэн. Эдгээр материаллаг болон процессын хуулиудад гэмт хэргийн улмаас хохирогчид учирсан эдийн болон эдийн бус хохирол, хор уршгийн талаарх ойлголт, ухагдахууныг хуульчилсан боловч түүнийг хэрэгжүүлэх арга замыг тодорхой журамлаагүйн улмаас хохирогчид хуулийн үзэл санаа, шаардлагын дагуу хохирлоо бодитоор үнэлүүлж, нөхөн төлүүлж чадахгүй байна.

Хэдийгээр Эрүүгийн хуулийн “гэм буруугаа хүлээсэн, хохирлоо нөхөн төлсөн этгээдийг ялаас чөлөөлж эрүүгийн хариуцлагын бусад хэлбэрийг хэрэглэх” эрх зүйн зохицуулалтын нөлөөгөөр хохирол нөхөн төлүүлэх байдалд зарим нэг ахиц гарсан боловч гүнзгийрүүлэн судлах шаардлагатай. Иймд өнөөдөр төрийн зүгээс иргэдийнхээ зөрчигдсэн эрхийг хамгаалах механизмын нэг хэлбэр болох гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах, үнэлэх, нөхөн төлүүлэх үндэсний тогтолцоо бүрдүүлэх нь тулгамдсан асуудал гэж үзэж байна.

1.2. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Энэхүү судалгаагаар Монгол Улсын хэмжээнд эрүүгийн хэргийн хэрэг бүртгэх, мөрдөн шалгах, яллах, шүүн таслах ажиллагааны явцад гэмт хэргийн хохирол, хор уршгийг тогтоох, үнэлэх, хохирол, хор уршгийн мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх хэмжээг тодорхойлох, түүнийг нөхөн төлүүлэх эрх зүйн орчин болон шүүхийн практикийг судлах, хохирогчийн эрх ашгийг баталгаатай хангаж хамгаалахуйц эрх зүйн орчин бүрдүүлэх боломжийг судалж, санал дэвшүүлэхийг зорилоо.

Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэв. Үүнд:

- Монгол Улс дахь хохирол нөхөн төлүүлэлтийн талаарх тоон мэдээлэлд статистикийн боловсруулалт хийх;
- Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын төрөл, хэмжээг тогтоож, үнэлж буй байдалд дүн шинжилгээ хийх;

- Шүүхээс гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг шийдвэрлэж буй байдалд дүн шинжилгээ хийх;
- Гэмт хэргийн улмаас учирсан хор уршгийг тогтоож буй байдал, гэмт хэргийн хохирол учирсантай холбогдуулан иргэний нэхэмжлэл гаргасан эсэх, түүнийг шийдвэрлэсэн байдалд дүн шинжилгээ хийх;
- Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг нөхөн төлүүлсэн байдалд дүн шинжилгээ хийх;
- Гэмт хэргийн хохирлыг тогтоох, үнэлэх, хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбоотой Эрүүгийн хууль тогтоомжийн зохицуулалтад буй хийдэл, давхардал, шүүхийн практикт учирч буй хүндрэл бэрхшээлийг тодорхойлох;
- Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын төрөл, хэмжээг тогтоох, үнэлэх, шийдвэрлэх, нөхөн төлүүлэх арга хэмжээний талаар санал, зөвлөмж боловсруулах зэрэг болно.

1.3. СЭДВИЙН СУДЛАГДСАН БАЙДЛЫН ТОЙМ

Монгол Улсын хэмжээнд гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлтийн талаар хувь судлаачдын хийсэн судалгаа, өгүүлэл, нийтлэл байж болохыг эс тооцвол тусгайлан судалсан цөөн тооны судалгааны ажил байна. Үүнд:

- Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс 2007 онд хийсэн “Гэмт хэргийн улмаас учирсан хохирол”;
- Хүний эрхийн Үндэсний комиссоос 2010 онд хийсэн “Монгол Улсад эдийн бус гэм хорыг нөхөн төлүүлж буй практик”;
- Үндэсний статистикийн хорооноос 2014 онд хийсэн “Гэмт хэргийн хохирогчийн өнөөгийн байдал”;
- Улсын Ерөнхий Прокурорын газраас 2018 онд хийсэн “Хүний эрүүл мэндэд хохирол учруулсан хэрэгт хохирол тогтоосон болон хохирол нөхөн төлүүлсэн байдал” сэдэвт судалгааны ажлууд тус тус хийгджээ.

Дээрх судалгааны ажлуудад гэмт хэргийн хохирлыг нөхөн барагдуулж буй байдал, хохирогчийн эрхийн хэрэгжилтийн төлөв байдлыг тодорхойлсон байх боловч энэ нь өмнөх хууль зүйн орчны хүрээнд хийгдсэн, тухайн судалгаагаар дэвшүүлсэн асуудлыг 2012-2016 онд явагдсан эрх зүйн шинэчлэлийн хүрээнд шийдвэрлэхийг зорьсон байна. Хэдий тийм ч тухайн үед байсан нөхцөл байдал төдийлөн өөрчлөгдөөгүй, хохирогчийн эрхийг хамгаалах, хохирол нөхөн барагдуулах ажиллагаанд ахиц гараагүй байж болох нөхцөл илэрсэн тул энэхүү судалгааг хийх шаардлагатай болсон.

Тухайлбал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээг тогтоох буюу үнэлэх ажиллагаа зохих журмын дагуу хийгддэггүй, эдийн бус хөрөнгө болон эд хөрөнгийн хохирлын хэмжээг тогтоох асуудал маргаантай байгааг дээрх судалгаагаар тогтоосон байна. Мөн хүний эрүүл мэнд, амь нас, сэтгэл санаанд учирсан хохирлын хэмжээг тогтоох буюу үнэлэх аргачлал, журмыг шинэчлэх шаардлагатай гэж дүгнэжээ.

Ялангуяа хүний амь нас, эрүүл мэнд, сэтгэл санаа, нэр төр, алдар хүндэд учирсан хохиролд үнэлгээ хийх, хохирлыг тогтоох аргачлал гараагүй байгааг анхаарч, хохирогчид учирсан хохирлыг арилгах, эрхийг нь нөхөн сэргээхэд зориуд бодлогын хэрэгжилтийг чиглүүлэх талаарх зөвлөмжийг дээр дурдсан судалгаануудад өгч байжээ.

Тухайн судалгаануудаас үзэхэд эдийн бус хохирлыг мөнгөн хэлбэрээр арилгуулахаар гаргасан нэхэмжлэлийн ихэнхийг хэрэгсэхгүй болгох, нэхэмжлэлийн шаардлагын хэмжээг эрс багасгах гэх мэтээр шийдвэрлэдэг, гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, хэр хэмжээг нотлох, нэхэмжлэлийг хангах арга хэмжээ авах ажиллагаа төдийлөн хийгддэггүй, өөр өөр байр сууринаас ханддагийг тогтоосон байна. Үүнээс үзэхэд дээрх судалгаануудын дүгнэлт зөвлөмжүүд өнөөг хүртэл хэрэгжээгүй, тулгамдсан асуудлууд шийдвэрлэгдээгүй хэвээр байна гэж үзлээ.

1.4 СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ БА ХАМРАХ ХҮРЭЭ

а) Тоон судалгаа

Судалгааны хүрээнд шинэ хууль хэрэгжиж эхэлснээс хойш гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлыг тодруулах, түүнд дүн шинжилгээ хийхийн тулд цагдаагийн байгууллага, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас гаргадаг албан ёсны тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийв.

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулиар 2017 оны 7 дугаар сарын 1-ээс 2019 оныг хүртэлх хугацаанд гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээг тогтоож,¹ нөхөн төлүүлсэн байдлыг хэрэг бүртгэх, мөрдөн шалгах, шүүн таслах ажиллагааны шат тус бүрээр тоо бүртгэлийн аргаар судлав. Дурдсан хугацаанд судалж буй хэргийн онцлогт тохируулан боловсруулсан цагдаа, прокурор, шүүхийн захиргааны байгууллагаас гаргадаг тоо, мэдээ, статистик зөрүүтэй гардаг тул тухайн байгаа тоон мэдээг засварлахгүйгээр оруулсан болно.²

б) Чанарын судалгаа

Чанарын судалгааг явуулахдаа Эрүүгийн хуулийг хэрэглэж шүүхээр шийдвэрлэсэн хэргүүдээс гэмт хэргийн төрөл, хохирол болон хор уршгийн төрөл тус бүрээр түүвэрлэн сонгож хавтаст хэрэгт дүн шинжилгээ хийх аргаар судлав. Судалгааны баримт

¹ Зарим тохиолдолд тухайн бүртгэгдсэн хэргийн тоо хохирогчийн тооноос их байгаа бөгөөд энэ нь хэрэг бүртгэлийн шатанд 2020 оны 2 дугаар сарын 24-ний өдрийг хүртэлх хугацаанд (Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан нь энэ өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн) хохирогчийг тогтоохгүйгээр, эсхүл хохирогч болох хүнийг гэрчээр тооцож мэдүүлэг авч мөрдөн шалгах ажиллагаа явуулдаг байсантай холбоотой байна.

² Тухайлбал, 2018 онд өмнөх оноос нийт цагдаагийн байгууллагад хандсан гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн тоо 5,500 орчмоор өссөн бөгөөд Эрүүгийн хууль тогтоомжийн шинэчлэлийн явцад буюу 2017 оны 7 дугаар сарын 1-ээс хойш бүртгэлийн системийн өөрчлөлтөөс хамаарч өсөж, буурсан байж болох талтай. Прокурорын байгууллагын 2018 оны тоон мэдээгээр 47,672 эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан нь цагдаагийн байгууллагын бүртгэсэн хэргээс 11 мянгаар илүү байна. Энэ нь хэргийн үйлдэл бүрт эрүүгийн хэргийн дугаар авах, эсхүл хэргийг нэгтгэх, тусгаарлахтай холбоотойгоор прокурорын гаргасан шийдвэрийн тооноос хамаарчээ.

бичигт тэмдэглэгдсэн тодорхой тохиолдлууд, тэдгээрийн онцлог шинжийг тоон судалгааны аргаар илэрхийлснээр тоон болон чанарын мэдээллийг харилцан баталгаажуулах байдлаар үнэн зөв дүгнэлтэд хүрэх давуу талыг бидэнд олгосон.

Түүнчлэн, дээр дурдсан хугацаанд эрүүгийн хэрэгт учирсан хохиролтой холбогдуулан гаргасан иргэний нэхэмжлэлийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг мөн түүврийн аргаар сонгож, хавтаст хэрэгт дүн шинжилгээ хийх аргаар судаллаа. Судалгаанд хамрагдсан хэргийн төрлөөс хамаараад судлаач нар хэрэг бүрт тохирсон асуумжийг өөр өөрийн хувилбарт тохируулан боловсруулсан болно.

Кейс судалгааны хүрээнд дээрх зорилтыг хангах үүднээс 2017-2018 онд үйлдэгдсэн 10.1 дүгээр зүйл “Хүнийг алах” гэмт хэргийн 40, 11.1 дүгээр зүйл “Хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулах”, 11.4 дүгээр зүйл “Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол учруулах”, 11.6 дугаар зүйл “Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах” гэмт хэргийн нийт 150, 17.1 дүгээр зүйл “Хулгайлах” гэмт хэргийн 150, 17.2 дугаар зүйл “Дээрэмдэх” гэмт хэргийн 50, 17.3 дугаар зүйл “Залилах” гэмт хэргийн 50, 11.7 дугаар зүйл “Тэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” гэмт хэргийн 20, 12.1 дүгээр зүйл “Хүчиндэх гэмт хэргийн” 19, 27.1 дүгээр зүйл “Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг” гэмт хэргийн 30 хавтаст хэргийн материалыг тус тус түүвэрлэн авч судаллаа.

Хүснэгт 1.1. Кейс судалгаа хийсэн эрцүгийн гэмт хэргийн тоон мэдээлэл (2017 ба 2018 он)

№	Эрүүгийн хууль Зүйл, хэсэг	Бүртгэгдсэн гэмт хэрэг Ц.Б		Прокурорын хяналт		Шүүх Шийдвэрлэсэн хэрэг		Судалсан хэргийн тоо
		2017	2018	2017	2018	2017	2018	
1	10.1	189	192	463	374	196	164	40
2	11.1	398	295	420	653	340	351	26
3	11.4	645	401	688	1,052	535	626	24
4	11.6	7,406	8,128	7,789	12,479	3,036	5,757	100
5	11.7	243	210	101	519	59	115	20
6	12.1	376	519	649	1,105	191	282	19
7	17.1	12,222	12,328	17,496	23,428	1,416	1,553	150
8	17.2	1,233	1,497	2,101	2,992	188	301	50
9	17.3	2,996	5,372	4,362	9,356	273	454	50
10	27.10	1,291	1,215	2,303	2,661	731	1,021	30
Судлах гэмт хэрэг бүртгэгдсэн байдал		26,999	30,157	36,372	54,619	6,965	10,624	509
Улсын хэмжээнд бүртгэгдэж, хянаж, шийдсэн гэмт хэрэг		32,259	36,220	65,923	68,598	8,839	12,363	

Кейс судалгаа хийх хэрэг болон хэргийн тоог 2017, 2018 онд хуулийн байгууллагад бүртгэгдэн, мөрдөн шалгагдаж, шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн тоон мэдээллийг харьцуулах замаар сонгож, тодорхойлсон болно. Эрүүгийн хуулийн 10-29 дүгээр бүлгийн гэмт хэрэг тус бүрийн тоон мэдээллээс харахад улсын хэмжээнд түгээмэл үйлдэгдэж байгаа 10 төрлийн гэмт хэрэг байсан бөгөөд эдгээр 10 төрлийн гэмт хэргийн тоон мэдээлэлд тулгуурлан унших хэргийг түүврийн аргаар сонгон судаллаа.

Судлагдсан хэргүүдийн үнэн магадтай шинж нь нэгдүгээрт, судалгааны арга зүйн талаас кейс буюу тодорхой тохиолдлыг судалж байгаагийн хувьд түүврийн чанар, найдвартай байдал бүрэн хангагдсан гэж үзэж болох бол тоон шинжилгээний хувьд хохирол, хор уршгийг нөхөн төлөх үйл явцтай холбоотой ерөнхий дүр зургийг баримжаалан харах боломжийг олгож байгаагаар тайлбарлагдана. Хоёрдугаарт, судалгаанд ашигласан кейсүүдийг түүврийн аргаар сонгож байгаа, мөн хэрэг тус бүрийн мэдээлэл нь баримттай, баталгаажсан, үнэн зөв тул судалгааны үр дүн бодитой байх боломжтой буюу хохирол нөхөн төлүүлэлтийн шүүхийн практикийг дүгнэх боломжтойг илтгэнэ.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн бүлгээр нь авч үзвэл 2018 онд бүртгэгдсэн тухайн гэмт хэргийн 12 буюу 1.1 хувь нь Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг, 998 буюу 93.3 хувь нь Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 47 буюу 4.4 хувь нь Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 5 буюу 0.5 хувь нь Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг, 7 буюу 0.6 хувь нь Хүүхдийн эсрэг гэмт хэрэг, 1 буюу 0.1 хувь нь бусад төрлийн гэмт хэрэг тус тус эзэлж байна.

№	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2017 он	2018 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг Үүнээс: Хүнийг алах	721 189	714 192	-1.0 1.6	2.0 0.5
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	8812	9134	3.7	25.2
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	223	210	-5.8	0.6
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	573	621	8.4	1.7
	Үүнээс: Хүчиндэх	376	519	38.0	1.4
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	71	115	62.0	0.3
	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	18176	22468	23.6	62.0
	Хулгайлах	11321	12328	11.1	34.0
	Залилах	2996	5372	78.1	14.8
	Дээрэмдэх	1233	1497	25.8	4.1
	Мал хулгайлах	901	1096	14.8	3.0
	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	1069	314	-70.6	0.9
6	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	1525	1231	-19.3	3.4
	Үүнээс: Автогэврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	1291	1215	-5.9	3.4
7	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	5	15	3.0 дахин	0.04
8	Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг	-	1	-	0.0

Цаашид ч Монгол Улсад гарч байгаа хулгайлах, залилах, дээрэмдэх, хүний эрүүл мэндэд санаатай халдаж хөнгөн, хүндэвтэр, хүнд хохирол учруулах, зам, тээврийн хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг гэмт хэргүүд нийт гэмт хэргийн үнэмлэхүй массыг эзэлсэн хэвээр байхаар байна. Иймд дээрх 10 төрлийн гэмт хэрэг улсын хэмжээнд хамгийн түгээмэл үйлдэгддэг тул кейс судалгаа хийх замаар хохирол, хор уршгийн нөхөн төлүүлэлтэд дүн шинжилгээ хийсэн болно.

в) Судалгаанд ашигласан мэдээлэл

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийн хэмжээ, түүнийг нөхөн төлүүлсэн байдлыг тогтоох зорилгоор ЦЕГ, УЕПГ, ШЕЗ зэрэг байгууллагуудаас шаардлагатай мэдээллийг цуглууллаа. Статистик мэдээлэлтэй холбоотой нарийвчилсан судалгааг хийхдээ Монголын Криминологичдын холбооноос эрхлэн гаргадаг “Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном - 2017, 2018”-ыг ашиглан дүн шинжилгээ хийв. Мөн хохирол нөхөн төлүүлэлтийн шүүхийн практикт дүн шинжилгээ хийхдээ улсын хэмжээнд 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс 2019 оныг хүртэлх хугацаанд эрүүгийн хэргийн шүүхээр шийдвэрлэгдсэн 509 эрүүгийн хавтаст хэрэг, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг иргэний журмаар нэхэмжилж шийдвэрлэсэн 92 шүүхийн тогтоолыг тус тус боловсруулсан асуумжийн дагуу уншиж судаллаа.

ХОЁР. СУДАЛГААНЫ ТАЙЛАН

2.1. ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Хүний зөрчигдсөн эрхийг сэргээх нь эрх зүйн харилцаанд юу юунаас илүү чухал зүйл билээ. Гэтэл өнөөдөр хүн, хуулийн этгээд гэмт хэргийн улмаас учирсан хохирлоо барагдуулж, хор уршгаа нөхөн төлүүлж чадахгүй байсаар байна.

НҮБ-ын Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт болон Монгол Улсын Үндсэн хуульд “бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрх”-ийг хуульчилсан бөгөөд уг баримт бичгүүдэд “төр иргэнийхээ эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг нь сэргээх үүргийг хариуцах” тухай, Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт иргэнд “бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхийг”, 19 дүгээр зүйлд төрийн “хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг” тус тус заасныг хэрэгжүүлэх зорилгоор Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлан хэрэгжүүлээд даруй 3 жил гаруй болж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтыг гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон, шударгаар ял оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээхэд оршино гэж тодорхойлсон.³

³ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг.

2002 оны Эрүүгийн хуулийг баталснаас хойш цаг үеийн нөхцөл байдал, нийгмийн шаардлагаас шалтгаалан уг хуульд 13 удаа нэмэлт, өөрчлөлт орж, улмаар Эрүүгийн хуулийг шинэчлэн найруулах шаардлагатай гэж салбарын олон эрдэмтэн, судлаач үзсэнээр 2015 онд уг хуулийг шинэчлэн найруулсан билээ.

Эрүүгийн хуулийг шинэчлэн найруулах болсон нь Монгол Улсын Үндсэн хуулиар тунхагласан үнэт зүйлсийг материаллаг хуулиар хамгаалахдаа гэмт хэрэг, зөрчлийн шинжийг ойлгомжтой, хэрэглэхэд хялбар байдлаар, өнөөгийн нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн өөрчилж, томъёолохын зэрэгцээ хамгаалах шаардлагатай харилцааг шинээр тусгаж, хүний эрх, эрх чөлөө, хүний халдашгүй байдлыг хамгаалах хууль эрх зүйн баталгаатай орчныг бүрдүүлэхэд чиглэсэн юм. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан хүний суурь эрх, халдашгүй байдлыг илүү баталгаажуулсан, олон улсын нийтийн эрх зүйн хөгжлийн чиг хандлагад нийцсэн урт хугацаанд тогтвортой үйлчлэх хуулийг батлан гаргах зүй ёсны шаардлага бий болж улмаар Улсын Их Хурал Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгыг 2015 онд баталж, 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн. Гэмт хэргийн хохирол, уршгийг тогтоох, үнэлэх, хохирогчийн эрхийг хангах чиглэлээр дараах зохицуулалт үйлчилж байна. Үүнд:

1. Эрүүгийн хуулийн 2.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Энэ хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно”, “Энэ хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэг үйлдэж хохирол учруулсны улмаас үүссэн үр дагаврыг гэмт хэргийн хор уршигт тооцно” гэж хохирол, хор уршгийг ялгаж тодорхойлсон. Өөрөөр хэлбэл, гэмт хэргийн улмаас шууд учирсан үр дагаврыг хохирол, хохирол учирсны улмаас үүсэх үр дагаврыг хор уршигт тооцсон. Мөн 2002 оны Эрүүгийн хуульд хохирлыг бага бус, үлэмж, их, онц

их хэмжээний гэж 4 ангилж байсныг өөрчилж ноцтой, их, үлэмж, бага хэмжээний хохирол гэж ангилсан.⁴

Түүнчлэн тус зүйлд шүүх гэмт хэргийн хохирол, хор уршгийг тодорхойлж бодит хохирлыг нөхөн төлүүлэх, хор уршгийг арилгахад гарах зардлын мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх хэмжээг тогтоохоор хуульчилсан.

2. Шинэчлэн найруулсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн үзэл баримтлалыг үзвэл:
 - а. Хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий эд зүйлийн шинж байдал, үнэд хамаарах баримт сэлтийг мөрдөгч бэхжүүлэн, нотлох баримт болгох;
 - б. Шаардлагатай гэж үзвэл мөрдөгчийн магадалгаа, шинжээчийн дүгнэлтээр тогтоолгох;
 - в. Шүүхээс хэрэг маргааныг шийдвэрлэх явцдаа нотлох баримтад үндэслэн Эрүүгийн хуульд заасны дагуу эцэслэн барагдуулах хохирлын мөнгөн дүнг тогтоож хэвших зэрэг болно.
3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8.1 дүгээр зүйлд “Хохирогч”-ийг тодорхойлохдоо “Гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг хохирогч гэнэ” гэжээ. Мөн 8.2 дугаар зүйлд хохирогчийн 15 эрхийг хуульчлан тодорхойлсноос хохирсон эрхээ сэргээхтэй холбоотой дараах үндсэн 4 эрхийг хуульчилсан байна. Үүнд:
 - а. хэргийн бодит байдлыг тогтооход шаардлагатай эд зүйл, баримт бичиг, мэдээлэл, бусад баримтыг гарган өгч хавтаст хэрэгт бэхжүүлж тусгуулах;
 - б. гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг нэхэмжлэх, нөхөн төлүүлэх хүсэлт гаргах;

⁴ Эрүүгийн хуулийн 29 дүгээр зүйл 2002 он.

- в. эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүх, прокурор, мөрдөгчийн хууль зөрчиж учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх гомдол гаргах;
 - г. шинжээч томилсон тогтоол, шинжээчийн дүгнэлтийн өөрт хамааралтай хэсэгтэй танилцах.
4. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.5 дугаар зүйлд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тусгай мэдлэг зайлшгүй шаардагдсан эсхүл эд зүйл, хөрөнгийн үнэлгээ тогтоохоор шинжилгээ хийлгэхээр заасан бөгөөд энэ нь өмнө хэрэгжиж байсан хуулийн үед хийгдсэн байсан эд зүйлийн үнэлгээ гэсэн ойлголтыг халах зорилготой зохицуулалт юм.
- Мөн хуулийн 27.1 дүгээр зүйл болох “Шинжилгээ хийлгэх журам” гэсэн зохицуулалтад 2.2 дахь хэсэг болгон “хүний эрүүл мэндэд учирсан хохирлын шинж байдлыг тогтоох”-оор шинжилгээ хийлгэж болохоор заажээ.
5. Мөн Иргэний хуулийн зүйл заалтаас харвал хохирогчид учирч болох хохирлыг дараах байдлаар ангилж авч үзэж болохоор байна.
- а. Гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан бол учирсан хохирлыг Иргэний хуулийн 508, 509 дүгээр зүйлүүдэд заасан арга, хэлбэрээр арилгана. Гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан бол түүнийг оршуулахтай холбогдсон зардал болон гэм хор учруулсны төлбөрийн хэмжээг Иргэний хуулийн 508 дугаар зүйлийн 508.3-т зааснаар тогтоож байгаа жишигтэй байна.
 - б. Гэмт хэргийн улмаас бусдын эрүүл мэндэд гэм хор учирсан бол гэм буруутай этгээд Иргэний хуулийн 505, 506 дугаар зүйлүүдэд зааснаар хохирогчийн эмчилгээний зардал, хөдөлмөрийн чадвар алдсанаас олох байсан орлогын хэмжээгээр хохирлыг нөхөн төлнө. Олох байсан орлогын хэмжээг авах байсан цалин, орлого, авсан тэтгэвэр,

тэтгэмжийн зөрүүгээр тооцох тул хөдөлмөрийн чадвар алдсан этгээдийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ ихсэх, багасах тохиолдолд гэм хор учруулсны төлбөр Иргэний хуулийн 507 дугаар зүйлд зааснаар өөрчлөгдөнө. Эд хөрөнгөд учруулсан гэм хорыг тухайн эд хөрөнгийг бүрэн бүтэн буцаан өгөх, эсхүл Иргэний хуулийн 510 дугаар зүйлийн 510.1-д зааснаар адил нэр, төрөл, чанарын эд хөрөнгө өгөх, гэмтсэн эд хөрөнгийг засах, мөнгөөр учирсан хохирлыг нөхөн төлөх зэрэг аргаар арилгаж болохоор байна.

- в. Гэмт хэргийн улмаас эд хөрөнгөд учруулсан гэм хорыг тухайн эд хөрөнгийг бүрэн бүтэн буцаан өгөх эсхүл Иргэний хуулийн 510 дугаар зүйлийн 510.1-д заасны адил нэр, төрөл, чанарын эд хөрөнгө өгөх, гэмтсэн эд хөрөнгийг засах, мөнгөөр учирсан хохирлыг нөхөн төлөх зэрэг аргаар арилгана.
 - г. Гэмт хэргийн улмаас учирсан эдийн бус хохирол: Бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан гэм буруутай этгээд эд хөрөнгийн хохирол арилгасан эсэхээс үл хамааран мөнгөн болон бусад хэлбэрээр арилгах эдийн бус гэм хорын хэмжээг Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийн 511.2-т зааснаар мэдээ тараасан арга хэрэгсэл, тарсан хүрээ, хохирогчийн сэтгэл санаанд учирсан үр дагавар зэргийг харгалзан тодорхойлно.⁵
6. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын асуудлыг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхдээ шүүх Иргэний хуулийн гэм хор учруулснаас үүсэх үүргийг зохицуулсан холбогдох зүйл, заалтыг баримтлан шийдвэрлэдэг байна. Мөн гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох асуудлыг Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 132 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Зарим төрлийн гэмт

⁵ Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг арилгах талаарх эрүүгийн байцаан шийтгэх болон иргэний хуулийн зарим зүйл, заалтыг эрүү, иргэний шүүн таслах ажиллагаанд хэрэглэх тухай Монгол Улсын дээд шүүхийн тогтоол, Дугаар 15, 2009 он

хэргийн хохирогчид төрөөс нөхөн төлбөр олгох журам”-ыг баримталдаг. Уг журамд зааснаар Эрүүгийн хуулийн “Хүнийг алах, Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах, Хүчиндэх, Хүнийг хүчээр алга болгох, Дээрэмдэх, Төрийн албан тушаалтны амь биед халдах, Эрүү шүүлт тулгах, Террор үйлдэх, Түрэмгий дайныг төлөвлөх, бэлтгэх, өдөөх, дэгдээх” зэрэг гэмт хэргийн улмаас амь насаа алдсан этгээдийн гэр бүлийн гишүүн, хүнд гэмтэл учирсан хохирогчид төрөөс нөхөн төлбөр олгох асуудлыг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 10 дугаар зүйлд зааснаар олгохоор зохицуулсан.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд дээрх гэмт хэргээс гадна “Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах, Бэлгийн мөлжлөг, Хүн худалдаалах, Хүн хулгайлах, Хүний цус, эс, эд, эрхтнийг хууль бусаар авах, Хууль бусаар үр хөндөх, Хүүхдийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах, Хүүхдийг хаях, төөрүүлэх, тэнүүчлэлд хүргэх, Хүүхэд худалдах, Хүүхэдтэй хэрцгий харьцах, Хүүхдийг асран хамгаалах үүргээ үл биелүүлэх” зэрэг гэмт хэргийн хохирогчдод эмчилгээний болон оршуулгын зардал, хөдөлмөрийн чадвараа алдсанаас дутуу авсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг нөхөн төлөхтэй холбоотой асуудлыг хуульчилжээ.

Гэмт хэргийн хохирогчид олгох нөхөн төлбөрийн хэмжээ нь шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тодорхойлогдох бөгөөд гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангаас хохирогчид олгосон нөхөн төлбөрийг шүүхийн шийтгэх тогтоолоор гэм буруутай болох нь тогтоогдсон этгээдээр санд буцаан төвлөрүүлэхээр хуульчилсан байдаг.

7. Төрийн зүгээс олгож байгаа нөхөн төлбөр нь дээрх хохирол нөхөн төлүүлэлтийн харилцааг зохицуулж байгаа боловч хүний амь нас, бие эрхтэн болон сэтгэл санааны хохирлыг үнэлэх асуудлыг бүрэн гүйцэд шийдвэрлэж чадахгүй байна. Гэмт хэргийн хохирлыг тогтоохтой холбоотой Шүүхийн шинжилгээний тухай хуульд заасныг үндэслэн гаргасан журам

үйлчилж байгаа бөгөөд хохирлын үнэлгээг тогтоож буй дээрх журам, тогтолцооноос гадна хэрэг бүртгэгч, мөрдөгч нар үнэлгээ хийлгэх эд зүйлийн шинж чанар, эдэлгээ, элэгдлийн байдлыг тогтоох ажиллагаа хийх замаар гэмт хэргийн хохирлын тодорхойлж байна.

2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад хохирол, хор уршиг, ноцтой хохирол зэргийг шинээр тодорхойлсон нь ихээхэн ач холбогдолтой болсон. Учир нь ямарваа нэгэн гэмт хэрэг гарлаа гэж бодоход тухайн гэмт хэргийн улмаас учирсан хохирол, түүнээс үүдэн гарсан хор уршиг нь ямар байсан гэдгийг тодорхойлсны үндсэн дээр хохирол нөхөн төлүүлэх асуудал яригдана. Түүнчлэн тухайн гэмт хэргээс учирсан хохирлыг бодитойгоор тогтооход нөгөө л хохирол, хор уршгийн хэр хэмжээ яригдана. Хохирол хор уршгийн хэмжээг ялгах, хохирлоо нөхөн төлөхөө илэрхийлэх, хэсэгчлэн төлөх, хохирол бүрэн барагдуулах талаар хууль зүйн ойлголтыг төлөвшүүлэх шаардлагатай.

Гэмт хэргийн улмаас хүн, хуулийн этгээдэд хохирол учруулсан бол хохирлыг нь барагдуулж, хор уршгийг арилгасны дараа оногдуулах ялыг хөнгөрүүлж, гэм бурууд нь тохирсон ял оногдуулах үзэл хандлага руу Монголын эрүүгийн эрх зүйн бодлого шилжиж байгаа учраас хуульчдаас хууль хэрэглээний шинэлэг ур чадвар эзэмших, урьд эзэмшсэн мэдлэгээ шинэчлэхийг шаардаж байна.

2.2. МОНГОЛ УЛС ДАХЬ ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС УЧИРСАН ХОХИРОЛ, ХОР УРШГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

2.2.1. 2017 болон 2018 оны гэмт хэргийн хохирогч, гэмт хэргийн улмаас учирсан хохирлын тоон мэдээлэл

Монгол Улсын хэмжээнд 2017, 2018 онд бүртгэгдсэн гэмт хэргийн улмаас хохирсон иргэн, хуулийн этгээдийн талаарх тоон мэдээний статистикийг Эрүүгийн хуулийн гэмт хэрэг тус бүрээр нарийвчлан боловсруулав.⁶

Монгол Улсын хэмжээнд 2017 онд 32,259 гэмт хэрэг бүртгэгдсэн бөгөөд гэмт хэргийн улмаас 37,173 иргэн, 86 хуулийн этгээд хохирч үүнээс 1,129 хүн нас барж, 10,513 хүн гэмтсэн байна. Гэмт хэргийн улмаас 198.1 тэрбум төгрөгийн хохирол учирч дээрх хохирлоос 74.5 тэрбум төгрөгийг буюу 37.6 хувийг нөхөн төлүүлжээ. 2018 онд 36,620 гэмт хэрэг бүртгэгдсэн бөгөөд гэмт хэргийн улмаас 33,566 хүн, 57 хуулийн этгээд хохирч, үүнээс 934 хүн нас барж, 9,283 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, нас барсан хүн 195 буюу 17.3 хувь, гэмтсэн хүн 1,230 буюу 11.7 хувиар тус тус буурсан байна. Гэмт хэргийн улмаас 193.3 тэрбум төгрөгийн хохирол учирч дээрх хохирлоос 32.4 тэрбум буюу 16.8 хувийг нөхөн төлүүлжээ.

2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдсөн Эрүүгийн хуулийн гол үзэл санаа болох хохирогчийн эрхийг хангах, хохирол хор уршгийг арилгах талаар зохицуулсан Эрүүгийн хуулийн 2.5 дугаар зүйл “Гэмт хэргийн хохирол, хор уршиг”, Эрүүгийн хуулийн 6.7 дугаар зүйл болох “Гэм буруугаа хүлээсэн хүнд оногдуулах эрүүгийн хариуцлагын талаарх” зүйл, хэсэг заалтууд нь бодитоор хэрэгжиж эхэлсний эерэг үр дагавар 2017 онд гарсан буюу хохирол нөхөн төлүүлэлт 2016 онтой харьцуулахад 30.5 тэрбум төгрөгөөр

⁶ ЦЕГ-т бүртгэгдсэн хохирогч, хохиролтой холбоотой тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийхээс илүүтэйгээр улсын хэмжээний болон гэмт хэрэг тус бүрийн хохирол нөхөн төлүүлэлтийн нөхцөл байдлыг гаргаж ирэх үүднээс тоон мэдээлэлд боловсруулалт хийсэн болно.

буюу 32.78 хувиар өссөн байна. Гэвч 2018 онд нөхөн төлүүлсэн хохирол 42.1 (56.5 хувь) тэрбум төгрөгөөр буурчээ.

Эрүүгийн хуулийн 6.7 дугаар зүйлийн 6.7.1 дэх хэсэгт “Гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдсон, гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүний гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршгийн шинж чанар, хувийн байдлыг харгалзан шүүх дараах байдлаар хорих ялыг хөнгөрүүлж, ялаас чөлөөлж, албадлагын арга хэмжээ хэрэглэж болно” гэж заасан. Улмаар гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлсөн, нөхөн төлөхөө илэрхийлсэн бол эрүүгийн хариуцлагыг тодорхой хэмжээгээр хөнгөрүүлэх, бүр ялаас чөлөөлөх хүртэл арга хэмжээ авахаар зохицуулсан. Харамсалтай нь шударга ёсыг сэргээн тогтоох үзэл санааг амилуулах энэхүү зохицуулалтыг ихээхэн явцууруулж зөвхөн хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэгт хэрэглэхээр хуульчилсны улмаас хорихоос өөр төрлийн ял шийтгэгдэх тохиолдолд эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх боломж хязгаарлагдаж, ялтанд ашиггүй болсон тул гэмт этгээд хохирлоо төлөхгүй байхад хүрч байна. Манай судалгаагаар Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан 424 заалтын 48.3 хувь буюу 205 заалтад хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх боломжтой, харин хорих ял оногдуулахаар заагаагүй 50 хөнгөн гэмт хэрэгт Эрүүгийн хуулийн 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “тэнсэх” эрх зүйн зохицуулалтыг хэрэглэх боломжгүй болох нь тогтоогдсон.

Эрүүгийн хуулийн хэрэгжилтийн явцад хохирол нөхөн төлүүлэлт ийнхүү буурсан нь 2015 онд шинээр баталсан Эрүүгийн хуульд 2017 оны 5 дугаар сард нэмэлт өөрчлөлт оруулахдаа хөнгөн ангиллын 51 гэмт хэрэгт оногдуулах хорих ялыг хассантай холбоотойгоор яллагдагч хэргийн хохирол, хор уршгаа барагдуулсан ч тэнсэх боломжгүй болсон байна.⁷ Өөрөөр хэлбэл, нийтлэг гардаг хөнгөн ангиллын 50 гэмт хэрэг тэнсэх боломжгүй болсон учир яллагдагч, шүүгдэгчээс хохирлоо барагдуулах үзүүлэлт буурчээ.

⁷ Судалгааны ажлын явцад 2020 оны 1 дүгээр сарын 14-нд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр дээрх зохицуулалтад нэмэлт өөрчлөлт оруулж шийдвэрлэсэн байна.

Ялын үндсэн шинж болох хохирол, хор уршгаа барагдуулсан тохиолдолд тэнсэх зохицуулалтыг илүү тодорхой болгоогүйгээс гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлөх явдал буурах хандлагатай болжээ.⁸

Хүснэгт 2.1. 2017 болон 2018 онд гэмт хэргийн улмаас учирсан хохирлын талаарх тоон мэдээ⁹ (он тус бүрээр)

	Хохирогч бүгд	Иргэн	Үүнээс		Хуулийн этгээд	Учирсан хохирол бүгд (сая.төг)	Нөхөн төлүүлсэн (сая.төг)
			Нас барсан	Гэмтсэн			
2017	37,259	37,173	1,129	10,513	86	198.07 тэрбум	74.5 тэрбум
2018	33,623	33,566	934	9,283	57	193.3 тэрбум	32.4 тэрбум

2017 онд гэмт хэргийн улмаас 37,259 иргэн, хуулийн этгээд хохирсон бөгөөд үүнээс 37,173 буюу 99.8 хувь нь иргэн, 86 буюу 0.2 хувь нь хуулийн этгээд хохирсон үзүүлэлттэй байгаа бол 2018 онд гэмт хэргийн улмаас 33,623 иргэн, хуулийн этгээд хохирсон бөгөөд үүнээс 33,566 буюу 99.8 хувь нь иргэн, 57 буюу 0.2 хувь нь хуулийн этгээд хохирсон үзүүлэлттэй байна.

⁸ Гэмт хэргийн цагаан ном 2018 он.

⁹ ЦЕГ-ын мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны статистик мэдээллийн албанаас ирүүлсэн тоон мэдээ

2.2.2. Гэмт хэргийн улмаас нас барсан иргэдийн талаарх тоон мэдээ¹⁰

Хүснэгт 2.2. Гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн талаарх тоон мэдээ

Он	Нийт хохирогч	Иргэн	Нас барсан хүн
2017	37,259	37,173	1,129
2018	33,623	33,566	934
Дүн	70,882	70,739	2,063

2017 онд 37,173 хүн гэмт хэргийн улмаас хохирсон бөгөөд үүнээс 3 хувь буюу 1,129 хүн нас барсан бол 2018 онд 33,566 хүн гэмт хэргийн улмаас хохирсноос 2.8 хувь буюу 934 хүн нас баржээ.

2.2.3. Гэмт хэргийн улмаас эрүүл мэндээрээ хохирч гэмтсэн иргэдийн талаарх тоон мэдээ¹¹


Хүснэгт 2.3. 2017 болон 2018 онд гэмт хэргийн улмаас эрүүл мэндээрээ хохирсон нөхцөл байдлын талаарх тоон мэдээлэл

Он	Гэмтсэн хүн	Гэмтлийн зэрэг			Нас			
		Хөнгөн	Хүндэвтэр	Хүнд	18 хүртэлх	18-30	31-35	36-аас дээш
2017	10,513	8,344	1,404	765	1,251	4,350	1,785	3,127
2018	9,283	7,444	1,261	578	1,073	5,604	600	2,006
Дүн	19,796	15,788	2,665	1,343	2,324	9,954	2,385	5,133

¹⁰ Гэмт хэргийн цагаан ном 2017, 2018


¹¹ ЦЕГ-ын мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны статистик мэдээллийн албанаас гаргасан тоон мэдээлэл

График 2.1. Гэмт хэргийн улмаас эрүүл мэндээрээ хохирсон иргэдийн талаарх тоон мэдээ



2017 онд 37,173 хүн гэмт хэргийн улмаас хохирсон бөгөөд үүнээс 28.3 хувь буюу 10,513 хүн эрүүл мэндээрээ хохирсон бол 2018 онд энэ үзүүлэлт нийт 33,566 болж буурчээ. Тэдгээрээс 9,283 (25 хувь) хүн эрүүл мэндээрээ хохирчээ.


График 2.2. Гэмт хэргийн улмаас эрүүл мэндээрээ хохирсон иргэдийн гэмтлийн зэрэг



2017 онд 10,513 хүн гэмт хэргийн улмаас эрүүл мэндээрээ хохирсноос 79.4 хувь нь (8,344 хүн) хөнгөн гэмтэл, 13.4 хувь нь (1,404 хүн) хүндэвтэр гэмтэл, 7.3 хувь нь (765 хүн) хүнд гэмтэл авсан бол 2018 онд 9,283 хүн гэмтсэнээс 80.2 хувь нь (7,444 хүн) хөнгөн гэмтэл, 13.6 хувь нь (1,262 хүн) хүндэвтэр гэмтэл, 6.2 хувь

нь (578 хүн) хүнд гэмтэл авч эрүүл мэндээрээ хохирчээ (График 2.2-ыг харна уу). 2017 болон 2018 оны байдлаар эрүүл мэндээрээ хохирч гэмтсэн иргэдийн гэмтлийн зэргийг харвал хүнд гэмтлийн зэрэг 7 хувь, хүндэвтэр гэмтлийн зэрэг 13 хувь, хөнгөн гэмтлийн зэрэг 80 хувийг тус тус эзэлж байна.

График 2.3. Гэмт хэргийн улмаас эрүүл мэндээрээ хохирсон иргэдийн насны байдал



2017 болон 2018 онд гэмтсэн 19,796 хүний насны байдлыг авч үзвэл, 18 хүртэлх насны 2,324, 18-30 насны 9,954, 31-35 насны 2,385, 36-аас дээш насны 5,133 хүн тус тус гэмт хэргийн улмаас эрүүл мэндээрээ хохирч гэмтжээ (График 2.3-ыг харна уу).

2.2.4. Гэмт хэргийн улмаас эд хөрөнгөөрөө хохирсон иргэдийн талаарх тоон мэдээ

Хүснэгт 2.4. Гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн хохирлын талаарх тоон мэдээ

№	Он	Учирсан нийт хохирол (сая.төг)	Битүүмжилсэн хөрөнгө (сая.төг)	Нөхөн төлүүлсэн хохирол (сая.төг)
1	2017	198073.2	3668.5	74508.1
2	2018	193315.1	12777.3	32444.1
	Дүн	391388.3	49445.8	106952.1

График 2.4. Гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн хохирол, нөхөн төлүүллэлт (сая төгрөгөөр)





График 2.5. Гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн хохирол, битүүмжилсэн эд хөрөнгө (сая төгрөгөөр)



Дээрх судалгаанаас харахад улсын хэмжээнд гэмт хэргийн улмаас 2017 онд 37,259 хүн, хуулийн этгээд хохирч 198.1 тэрбум төгрөгийн хохирол учирч дээрх хохирлоос 74.5 тэрбум төгрөгийг буюу 36.7 хувийг нөхөн төлүүлжээ. Хохирол нөхөн төлүүлэхтэй холбоотойгоор 36.6 тэрбум төгрөгийн эд хөрөнгийг битүүмжилсэн байна. 2018 онд 33,620 гэмт хэргийн улмаас 33,623 хүн, хуулийн этгээд хохирч 193.3 тэрбум төгрөгийн хохирол учирч дээрх хохирлоос 32.4 тэрбум буюу 16.8 хувийг нөхөн төлүүлсэн бөгөөд хохирол нөхөн төлүүлэхтэй холбоотойгоор 12.8 тэрбум төгрөгийн эд хөрөнгийг битүүмжилсэн байна.

2.2.5. Шүүх эмнэлгийн статистик

Гэмт хэргийн статистик үзүүлэлт болон бусад хууль сахиулах байгууллагаас гаргадаг тоон мэдээллээс үзвэл гагцхүү бие махбодод учирсан эрүүл мэндийн статистикийг гаргаж иржээ. Өөрөөр хэлбэл, сэтгэцийн эрүүл мэнд, эдийн бус хохирлыг үнэлж тооцсон статистик мэдээ одоогоор Монгол Улсад гарахгүй байна. Хүний эрүүл мэндийн хохирлыг Хууль зүй, дотоод хэргийн сайд болон Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн сайдын хамтарсан тушаалаар баталсан “Гэмтлийн зэрэг тогтоох журам”-ын дагуу үнэлж байгаа билээ. ШШҮХ-ийн тайлангийн мэдээлэлд дурдсан гурван жилийн дунджаас үзвэл, нэг жилд 30,100 орчим хүн гэмтлийн зэрэг тогтоолгох шинжилгээ хийлгэхээр ханддагаас 16,400 хүн хөнгөн гэмтэл, 2,300 хүн хүндэвтэр гэмтэл, 1,260 хүн хүнд гэмтлийн зэрэг тогтоолгожээ.¹² Дээрх тоон мэдээнээс харахад, хүний эрүүл мэндэд хохирол учруулах бүртгэгдсэн хэргүүдээс даруй 3 дахин их байгаа нь энэ төрлийн гэмт хэрэг нуугдмал, хуулийн байгууллагаас хэрэг нээхээс татгалзсан, хаасан байж болохыг харуулж байна.

2.3. ТОДОРХОЙ ТӨРЛИЙН ГЭМТ ХЭРЭГ ТУС БҮРИЙН ХОХИРОЛ НӨХӨН ТӨЛҮҮЛЭЛТИЙН ТАЛААРХ ТООН МЭДЭЭЛЭЛ, СТАТИСТИК

Цагдаагийн байгууллага 2017 оны гэмт хэргийн статистик мэдээг шинээр хэрэгжиж эхэлсэн 2015 оны Монгол Улсын Эрүүгийн хууль, 2002 оны Эрүүгийн хууль гэсэн хоёр байдлаар гаргажээ. 2002 оны Эрүүгийн хуульд байсан зарим зүйл анги 2015 оны эрүүгийн хуулиас хасагдсан, эсхүл өөр гэмт хэргийн шинжид хамаарч өөрчлөгдсөн тул 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн Эрүүгийн хуулийн зүйл ангиудыг 2002 оны Эрүүгийн хуулийн ижил төстэй гэмт хэргийн шинжтэй жишиж 2017 оны гэмт хэргийн статистик мэдээллийг гаргасан тул зарим тоон мэдээ зөрж болно. Мөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх

¹² Шүүхийн шинжилгээний хүрээлэнгийн 2012-2016 оны үйл ажиллагааны тайлангаас

тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийг шалгах ажиллагааг хэрэг бүртгэлтэд тооцсон бөгөөд цагдаагийн байгууллага гэмт хэргийн статистик мэдээллийг гаргахдаа хэрэг бүртгэлтийн хэргийн тоог бүртгэгдсэн гэмт хэргийн тоо гэж үзжээ. Гэтэл хэрэг бүртгэлтийн хэрэг нээгээд шалгах явцад тухайн үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй байх, эсхүл зөрчил байх боломжтой тул бүхэлд нь гэмт хэрэг гэж үзэх нь учир дутагдалтай байсан, тухайн онд гарсан нийт гэмт хэргийг 7 сарын 1-ээс хойш шинэчилж гаргахдаа цагдаагийн байгууллагын тоон мэдээ гаргах журмыг хуулийн агуулгад нийцүүлж шинэчилж чадаагүй байсан тул 2017 оны тоон мэдээ тухайн онд илт зөрүүтэй гарсан байна.

2.3.1. Эрүүгийн хуулийн аравдугаар бүлэг “Хүний амьд явах эрхийн эсрэг” гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлтийн талаарх статистик

Улсын хэмжээнд 2017 онд Эрүүгийн хуулийн аравдугаар дугаар бүлэгт заасан гэмт хэрэг 709 бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 758 хүн хохирсон байна. Нийт хохирсон иргэний 24.8 хувь буюу 191 нь эмэгтэй, 8.9 хувь буюу 69 нь 18 хүртэлх насны хүүхэд байжээ. Эрүүгийн хуулийн 10 дугаар бүлэг нь Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг бөгөөд дээрх бүлэгт заасан гэмт хэргүүдийн хохирол хүний амь нас байх хэдий ч Эрүүгийн хуулийн 2.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу дээрх бүлгийн санаатай гэмт хэргийн хувьд завдах үйлдэл байх боломжтой. Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэргийн улмаас 685 хүн нас барж, завдалтын улмаас 24 хүн гэмтсэн байна. Дээрх бүлэгт заасан гэмт хэргийн улмаас 822,822,715 төгрөгийн хохирол учирч 495,612,715 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, 211,400,000 төгрөгийн эд хөрөнгийг битүүмжлэх ажиллагаа хийгджээ.

2018 онд энэ төрлийн гэмт хэрэг 714 бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас нийт 647 хүн хохирчээ. Нийт 714 гэмт хэрэг бүртгэгдсэн ч 647 хүн хохирсон байгаа нь 1 хэрэг дээр 2-3 хэргийн дугаар давхардуулж авах, бүлэглэж гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд

тухайн гэмт хэргийн хамтран оролцогч бүрд хэрэг нээх, эсхүл нэг гэмт хэрэгт хоёр өөр газар хэрэг нээх зэрэг тохиолдлуудаас үүдсэн байх боломжтой.¹³ Нийт хохирсон иргэний 25.8 хувь буюу 167 нь эмэгтэй, 7.3 хувь буюу 47 нь 18 хүртэлх насны хүүхэд байжээ. Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэргийн улмаас 558 хүн нас барж, 34 хүн гэмтсэн байна. Дээрх бүлгийн гэмт хэргийн улмаас 1,164,014,696 төгрөгийн хохирол учирч 895,864,696 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, 551,150,000 төгрөгийн эд хөрөнгийг битүүмжлэх ажиллагаа хийгджээ. Энэ төрлийн гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлтийн байдал 2017 онд 60.2 хувьтай байсан бол 2018 онд 76.9 хувьтай болсон буюу хохирол нөхөн төлүүлэлт өмнөх оноос 16.7 хувиар өсжээ.

Хүснэгт 2.5. Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлт¹⁴

Зүйл анги	Бүртгэгдсэн гэмт хэрэг		Хохирсон бүгд		Хохирлын мөнгөн дүн	
	2017 он	2018 он	2017 он	2018 он	2017 он	2018 он
10.1	189	192	191	196	529,622,715	948,082,000
10.2	1	2	1	2	0	0
10.4	470	459	517	390	136,900,000	133,100,000
10.5	4	8	4	5	5,500,000	0
10.6	45	53	45	54	150,800,000	82,832,696
Нийт	709	714	758	647	822,822,715	1,164,014,696
Үүнээс						
Зүйл анги	Нөхөн төлүүлсэн хохирол		Битүүмжилсэн хөрөнгө			
	2017 он	2018 он	2017 он	2018 он		
10.1	381,562,715	742,032,000	106,300,000	533,150,000		
10.2	0	0	0	0		
10.4	85,750,000	80,500,000	101,000,000	0		
10.5	5,500,000	0	0	0		
10.6	22,800,000	73,332,696	4,100,000	18,000,000		
Нийт	495,612,715	895,864,696	211,400,000	551,150,000		

¹³ Дүүргийн цагдаагийн газрын гомдол мэдээлэл, бүртгэл хариуцдаг албан тушаалтнаас зөрүүтэй тоон мэдээллийн талаар авсан тодруулга

¹⁴ ЦЕГ-ын статистик мэдээллийн албанаас ирүүлсэн тоон мэдээ

Энэ төрлийн гэмт хэргээс 10.1 дүгээр зүйл “Хүнийг алах” гэмт хэргийн улмаас иргэдэд учирч байгаа хохирлын мөнгөн дүн тус бүлгийн бусад гэмт хэргээс их байна. Уг гэмт хэргийн улмаас 2017 онд 191 хүн хохирч, гэмт хэргийн улмаас 529,622,715 төгрөгийн хохирол учирч 72 хувь буюу 381,562,715 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн бол 2018 онд 196 хүн хохирч, гэмт хэргийн улмаас 948,082,000 төгрөгийн хохирол учирч 78.3 хувь буюу 742,032,000 төгрөгийн хохирол нөхөн төлөгджээ.¹⁵

2.3.2. Эрүүгийн хуулийн арван нэгдүгээр бүлэг “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг” гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлтийн талаарх статистик

Улсын хэмжээнд 2017 онд Эрүүгийн хуулийн арван нэгдүгээр бүлэгт заасан гэмт хэрэг 8,812 бүртгэгдэж, уг гэмт хэргийн улмаас нийт 8,980 хүн хохирсноос 38.2 хувь буюу 3,430 нь эмэгтэй байжээ. Уг бүлгийн гэмт хэргийн улмаас 22 хүн нас барж, 8,024 хүн гэмтсэн байна. Эрүүгийн хуулийн 11.1 дүгээр зүйлийн 2.5-д “Энэ гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан бол” гэж хуульчилж өгсөн. Гэмт хэргийн улмаас 7,225,356,464 төгрөгийн хохирол учирч 5,150,054,003 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, 1,384,842,678 төгрөгийн эд хөрөнгийг битүүмжлэх ажиллагаа хийгдсэн байна.

2018 онд энэ төрлийн гэмт хэрэг 9,134 бүртгэгдэж, нийт 9,148 хүн хохирсноос 36.7 хувь буюу 3,363 нь эмэгтэй байжээ. Уг гэмт хэргийн улмаас 38 хүн нас барж, 7,957 хүн гэмтсэн. Дээрх бүлгийн гэмт хэргийн улмаас 7,604,372,529 төгрөгийн хохирол учирч 5,632,880,659 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, 765,625,771 төгрөгийн эд хөрөнгийг битүүмжлэх ажиллагаа хийгджээ. Энэ төрлийн гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлтийн байдал 2017 онд 71.3 хувьтай байсан бол 2018 онд 74 хувьд хүрч хохирол нөхөн төлүүлэлт өмнөх оноос 2.8 хувиар өсжээ.

¹⁵ Хүний амьд явах эрхийн эсрэг бүлгийн гэмт хэргүүд дотроос 10.1 дүгээр зүйл хүнийг алах гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлтийн нөхцөл байдлыг хавтаст хэрэгт дүн шинжилгээ хийх замаар судлан гаргаж ирэхээр сонгон авсан болно.

Хүснэгт 2.6. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирол нөхөн төлцүлэлт

Зүйл анги	Бүртгэгдсэн гэмт хэрэг		Хохирсон бүгд		Хохирлын мөнгөн дүн	
	2017 он	2018 он	2017 он	2018 он	2017 он	2018 он
11.1	398	295	396	294	811,758,853	781,878,000
11.2	2	1	3	2	1,500,000	0
11.3	61	31	57	26	137,370,000	75,799,000
11.4	645	401	652	410	795,675,000	586,655,176
11.5	57	68	52	63	86,928,000	126,800,000
11.6	7,406	8,128	7,580	8,151	5,301,056,611	5,939,680,353
11.7	243	210	240	202	91,068,000	93,560,000
Нийт	8,812	9,134	8,980	9,148	7,225,356,464	7,604,372,529
Үүнээс						
Зүйл анги	Нөхөн төлүүлсэн хохирол		Битүүмжилсэн хөрөнгө			
	2017 он	2018 он	2017 он	2018 он		
11.1	551,893,853	578,768,000	168,850,000	59,500,001		
11.2	2,000,000	0	0	0		
11.3	78,370,000	40,199,000	46,500,000	13,000,001		
11.4	547,331,100	458,363,316	328,510,002	83,086,751		
11.5	46,310,000	93,950,000	28,500,001	450,000		
11.6	3,874,426,050	4,383,620,343	802,052,675	600,589,017		
11.7	49,723,000	77,980,000	10,430,000	9,000,001		
Нийт	5,150,054,003	5,632,880,659	1,384,842,678	765,625,771		

Дээрх үзүүлэлтээс харвал, энэ төрлийн гэмт хэргээс Эрүүгийн хуулийн 11.1 дүгээр зүйл “Хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулах”, 11.4 дүгээр зүйл “Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол учруулах, 11.6 дугаар зүйл “Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах” гэмт хэргийн улмаас хохирч байгаа иргэдийн тоо бүлгийн бусад гэмт хэргүүдээс их байна.¹⁶ Эрүүл мэндийн хохирлын зэргээр төрөлжүүлэн үзвэл:

- Хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулах гэмт хэргийн улмаас 2017 онд 396 хүнд 811,758,853 төгрөгийн хохирол учирч 68 хувь буюу 551,893,853 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн бол 2018 онд 294 хүнд 781,878,000 төгрөгийн хохирол учирч 74 хувь буюу 578,768,000 төгрөгийн хохирол нөхөн төлөгджээ.
- Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол учруулах гэмт хэргийн улмаас 2017 онд 652 хүнд 795,675,000 төгрөгийн хохирол учирч 68.8 хувь буюу 547,331,100 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн бол 2018 онд 410 хүнд 586,655,176 төгрөгийн хохирол учирч 78.1 хувь буюу 458,363,316 төгрөгийн хохирол нөхөн төлөгджээ.
- Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах гэмт хэргийн улмаас 2017 онд 7,580 хүнд 5,301,056,611 төгрөгийн хохирол учирч 73.1 хувь буюу 3,874,426,050 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн бол 2018 онд 8,151 хүнд 5,939,680,353 төгрөгийн хохирол учирч 73.8 хувь буюу 4,383,620,343 төгрөгийн хохирол нөхөн төлөгджээ.
- Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн улмаас 2017 онд 240 хүнд 91,068,000 төгрөгийн хохирол учирч 54.5 хувь буюу 49,723,000 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн бол

¹⁶ Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг бүлгийн гэмт хэргүүд дотроос 11.1, 11.4, 11.6, 11.7 дугаар зүйлд заасан гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлтийн нөхцөл байдлыг хавтаст хэрэгт дүн шинжилгээ хийх замаар судлан гаргаж ирэхээр сонгон авсан болно.

2018 онд 202 хүнд 93,560,000 төгрөгийн хохирол учирч 83.3 хувь буюу 77,980,000 төгрөгийн хохирол нөхөн төлөгджээ.

2.3.3. Эрүүгийн хуулийн арван хоёрдугаар бүлэг “Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг” гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлтийн талаарх статистик

Улсын хэмжээнд 2017 онд Эрүүгийн хуулийн арван хоёрдугаар бүлгийн гэмт хэрэг 573 бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас нийт 564 хүн хохирсноос 95.3 хувь буюу 538 нь эмэгтэй, 42 хувь буюу 226 нь 18 хүртэлх насны хүүхэд байжээ. Уг бүлгийн гэмт хэргийн улмаас 3 хүн нас барж, 192 хүн гэмтсэн байна. Гэмт хэргийн улмаас 515,175,000 төгрөгийн хохирол учирч 350,895,000 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, 108,370,001 төгрөгийн эд хөрөнгийг хохирол нөхөн төлүүлэлттэй холбоотойгоор битүүмжлэх ажиллагаа хийгджээ.

2018 онд энэ төрлийн гэмт хэрэг 621 бүртгэгдэж, 579 хүн хохирсноос 96.7 хувь буюу 560 нь эмэгтэй байсан бол 55.3 хувь буюу 312 нь 18 хүртэлх насны хүүхэд байжээ. Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг бүлгийн гэмт хэргийн улмаас 2 хүн нас барж, 97 хүн гэмтсэн байна. Энэ төрлийн гэмт хэргийн улмаас 542,104,000 сая төгрөгийн хохирол учирч 358,866,000 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, 67,870,003 төгрөгийн эд хөрөнгийг битүүмжлэх ажиллагаа хийгджээ.¹⁷ Энэ бүлгийн хохирол нөхөн төлүүлэлтийн байдал 2017 онд 69,7 хувьтай байсан бол 2018 онд 68.1 хувь болж 1.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

¹⁷ Цагдаагийн байгууллага гэмт хэргийн статистик мэдээллийг гаргахдаа хэрэг бүртгэлтийн хэргийн тоог бүртгэгдсэн гэмт хэргийн тоо гэж үздэг тул хохирогчийн тоо бага гарсан. Тухайн үед хэрэг бүртгэлтэд хохирогчоор тогтоож, мэдүүлэг авах хуулийн зохицуулалтгүй байсан.

Хүснэгт 2.7. Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн
хохирол нөхөн төлцүлэлт

Зүйл анги	Бүртгэгдсэн гэмт хэрэг		Хохирсон бүгд		Хохирлын мөнгөн дүн	
	2017 он	2018 он	2017 он	2018 он	2017 он	2018 он
12.1	376	519	368	487	478,325,000	482,604,000
12.2	21	12	19	11	4,300,000	16,850,000
12.3	2	7	2	4	0	0
12.5	38	83	42	77	32,550,000	42,650,000
Нийт	573	621	564	579	515,175,000	542,104,000
Үүнээс						
Зүйл анги	Нөхөн төлүүлсэн хохирол		Билүүмжилсэн хөрөнгө			
	2017 он	2018 он	2017 он	2018 он		
12.1	324,595,000	319,066,000	65,520,001	65,870,003		
12.2	4,000,000	11,100,000	2,000,000	2,000,000		
12.3	0	0	0	0		
12.5	22,300,000	28,700,000	40,850,000	0		
Нийт	350,895,000	358,866,000	108,370,001	67,870,003		

Энэ төрлийн гэмт хэргээс Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйл буюу “Хүчиндэх” гэмт хэргийн улмаас хохирч байгаа иргэдийн тоо бүлгийн бусад гэмт хэргүүдийг бодвол илүү өндөр буюу нийт хохирогчдын 75 хувийг эзэлж байна. Уг гэмт хэргийн улмаас 2017 онд 368 хүн хохирч, гэмт хэргийн улмаас 478,325,000 төгрөгийн хохирол учирч 67.8 хувь буюу 324,595,000 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн бол 2018 онд 487 хүн хохирч, гэмт хэргийн улмаас 482,604,000 төгрөгийн хохирол учирч 66.1 хувь буюу 319,066,000 төгрөгийн хохирол нөхөн төлөгджээ.¹⁸

2.3.4. Эрүүгийн хуулийн арван гуравдугаар бүлэг “Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг” гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлтийн талаарх статистик

Улсын хэмжээнд 2017 онд Эрүүгийн хуулийн арван гуравдугаар бүлгийн гэмт хэрэг 71 бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас нийт 56 хүн хохирсноос 64.3 хувь буюу 36 нь эмэгтэй байжээ. Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэргийн улмаас 1 хүн гэмтсэн байна. Энэ төрлийн гэмт хэргийн улмаас 71,690,000 төгрөгийн хохирол учирч 6,030,000 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, 3,200,000 төгрөгийн эд хөрөнгийг битүүмжлэх ажиллагаа хийгджээ.

2018 онд энэ төрлийн гэмт хэрэг 115 бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас нийт 85 хүн хохирсон байна. Нийт хохирсон хүний 55.3 хувь буюу 47 эмэгтэй, 12.9 хувь буюу 11 нь насанд хүрээгүй хүүхэд байсан байна. Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг бүлгийн гэмт хэргийн улмаас 2 хүн гэмтсэн. Гэмт хэргийн улмаас 161,025,000 төгрөгийн хохирол учирч 15,825,000 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж 1,000,000 төгрөгийн эд хөрөнгийг битүүмжлэх ажиллагаа хийгджээ. Энэ төрлийн гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлтийн

¹⁸ Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг бүлгийн гэмт хэргүүд дотроос 12.1 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлтийн нөхцөл байдлыг хавтаст хэрэгт дүн шинжилгээ хийх замаар судлан гаргаж ирэхээр сонгон авсан болно.

байдал 2017 онд 8.4 хувьтай байсан бол 2018 онд 9.8 хувьтай болж 1.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 2.8. Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэргийн хохирол нөхөн төлүцлэлт

Зүйл анги	Бүртгэгдсэн гэмт хэрэг		Хохирсон бүгд		Хохирлын мөнгөн дүн	
	2017	2018	2017	2018	2017	2018
13.1	12	10	9	10	1,500,000	100,000
13.2	4	6	3	5	1,000,000	0
13.3	0	0	0	0	0	0
13.4	0	2	0	2	0	0
13.5	18	56	13	41	970,000	50,440,000
13.6	10	14	10	14	5,370,000	110,345,000
13.7	0	1	0	1	0	0
13.8	0	1	0	0	0	0
13.9	0	5	0	0	0	0
13.10	1	13	0	8	0	140,000
13.11	1	5	4	3	61,000,000	0
13.12	5	1	1	0	0	0
13.13	2	1	0	1	0	0
Нийт	71	115	56	85	69,840,000	161,025,000

Үүнээс				
Зүйл анги	Нөхөн төлүүлсэн хохирол		Битүүмжилсэн хөрөнгө	
	2017 он	2018 он	2017 он	2018 он
13.1-13.4	Нөхөн төлүүлсэн хохирол, битүүмжилсэн тохиолдол байхгүй			
13.5	100,000	6,800,000	0	1,000,000
13.6	5,130,000	9,025,000	3,200,000	0
13.7- 13.13	Нөхөн төлүүлсэн хохирол, битүүмжилсэн тохиолдол байхгүй			
Нийт	5,230,000	15,825,000	3,200,000	1,000,000

Энэ төрлийн гэмт хэргээс Эрүүгийн хуулийн 13.5 дугаар зүйл буюу “Заналхийлэх” гэмт хэргийн улмаас хохирч байгаа иргэдийн тоо бүлгийн бусад гэмт хэргүүдээ бодвол илүү өндөр буюу нийт хохирогчийн 38.3 хувийг эзэлж байна. Уг гэмт хэргийн улмаас 2017

онд 13 хүн хохирч, гэмт хэргийн улмаас 970,000 төгрөгийн хохирол учирч 10.3 хувь буюу 100,000 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн бол 2018 онд 41 хүн хохирч, гэмт хэргийн улмаас 50,440,000 төгрөгийн хохирол учирч 13.5 хувь буюу 6,800,000 төгрөгийн хохирол нөхөн төлөгджээ. Заналхийлэх гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлт 2017 онд 10.3 хувь, 2018 онд 13.5 хувьтай байна.¹⁹

2.3.5. Эрүүгийн хуулийн арван дөрөвдүгээр бүлэг “Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг” гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлтийн талаарх статистик

Улсын хэмжээнд 2017 онд Эрүүгийн хуулийн арван дөрөвдүгээр бүлэгт заасан гэмт хэрэг 29 бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас нийт 34 хүн хохирсноос 6 (17.6 хувь) нь эмэгтэй байжээ. Гэмт хэргийн улмаас 165,520,500 төгрөгийн хохирол учирч 103,450,000 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлжээ. Хохирол нөхөн төлүүлэхтэй холбоотой 91,000,000 төгрөгийн эд хөрөнгө битүүмжилсэн бөгөөд хохирол нөхөн төлүүлэлт 62.5 хувьтай байна.

2018 онд энэ төрлийн гэмт хэрэг 6 бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас нийт 6 хүн хохирсноос 4 нь эмэгтэй байжээ. Гэмт хэргийн улмаас гэмтсэн иргэн байхгүй байна. Гэмт хэргийн улмаас иргэдэд учирсан 1,050,000 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлээгүйн зэрэгцээ хохирол нөхөн төлүүлэхтэй холбоотой эд хөрөнгө битүүмжлээгүй ажээ. Энэ төрлийн гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлтийн байдал 2017 онд 62.5 хувьтай байсан бол 2018 онд огт хохирол гараагүй байна.

¹⁹ Дээр дурдсанчлан цагдаагийн байгууллага гэмт хэргийн статистик мэдээллийг гаргахдаа хэрэг бүртгэлтийн хэргийн тоог бүртгэгдсэн гэмт хэргийн тоо гэж үзэж байсан тул бүртгэгдсэн гэмт хэрэг болон хохирогч нарын тоо таарахгүй илт зөрүүтэй гарсан болно.

2.3.6. Эрүүгийн хуулийн арван тавдугаар бүлэг “Эрүүл мэндийн эсрэг” гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлтийн талаарх статистик

Улсын хэмжээнд 2017 онд Эрүүгийн хуулийн арван тавдугаар бүлгийн гэмт хэрэг 29 бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас нийт 22 хүн хохирсноос 81.8 хувь буюу 18 нь эмэгтэй байжээ. Эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн улмаас 11 хүн нас барж, 8 хүн гэмтсэн байна. Уг гэмт хэргийн улмаас 15,800,000 төгрөгийн хохирол учирснаас нөхөн төлүүлэлт огт хийгдээгүй ба харин 2,500,000 төгрөгийн эд хөрөнгийг битүүмжилжээ.

2018 онд энэ төрлийн гэмт хэрэг 33 бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас нийт 28 хүн хохирсноос 19 (67.8 хувь) нь эмэгтэй байжээ. Эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн улмаас 11 хүн нас барж, 10 хүн гэмтсэн байна. Гэмт хэргийн улмаас 48,000,000 сая төгрөгийн хохирол учирч 19,500,000 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, хохирол нөхөн төлүүлэхтэй холбоотойгоор эд хөрөнгө битүүмжлэх ажиллагаа хийгдээгүй ажээ. Энэ төрлийн гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлтийн үзүүлэлт 2017 онд 0 байсан бол 2018 онд 40.6 хувьтай байна.

Хүснэгт 2.9. Эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлт

Зүйл анги	Бүртгэгдсэн гэмт хэрэг		Хохирсон бүгд		Хохирлын мөнгөн дүн		Нөхөн төлүүлсэн хохирол		Битүүмжилсэн хөрөнгө	
	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018
15.1	24	32	22	28	15,800,000	48,000,000	0	19,500,000	2,500,000	0
15.3	Тухайн онуудад бүртгэгдсэн гэмт хэрэг байхгүй									
15.4										
15.5	4	0	2	0	0	0	0	0	0	0
15.6	1	1	0	0	0	0	0	0	0	0
Нийт	29	33	24	28	15,800,000	48,000,000	0	19,500,000	2,500,000	0

Дээрх хүснэгтээс харахад, Эрүүгийн хуулийн 15.1 дүгээр зүйл буюу “Эмнэлгийн тусламж үзүүлэхгүй байх” гэмт хэргээс бусад гэмт хэрэгт хохирол тогтоох, нөхөн төлүүлэх ажиллагаа хийгдээгүй байна.

2.3.7. Эрүүгийн хуулийн арван зургаадугаар бүлэг “Хүүхдийн эсрэг” гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлтийн талаарх статистик

Улсын хэмжээнд 2017 онд Эрүүгийн хуулийн арван зургаадугаар бүлгийн гэмт хэрэг 130 бүртгэгдсэн бөгөөд гэмт хэргийн улмаас 128 хүүхэд хохирсон байна. Хүүхдийн эсрэг гэмт хэргийн улмаас 1 хүүхэд нас барж, 6 хүүхэд гэмтжээ. Уг гэмт хэргийн улмаас 61,339,800 төгрөгийн хохирол учирч 39,789,800 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, 15,500,000 төгрөгийн эд хөрөнгийг битүүмжилсэн байна.

2018 онд энэ төрлийн гэмт хэрэг 21 бүртгэгдэж гэмт хэргийн улмаас 18 хүүхэд хохирчээ. Нийт хохирсон хүүхдийн 11 (61.1 хувь) нь охид байжээ. Хүүхдийн эсрэг гэмт хэргийн улмаас 2 хүүхэд гэмтжээ. Дээрх гэмт хэргийн улмаас 4,000,000 төгрөгийн хохирол учирч 2,300,000 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн бөгөөд хохирол нөхөн төлүүлэхтэй холбоотой эд хөрөнгө битүүмжлэх ажиллагаа хийгдээгүй. Дээрх бүлгийн хохирол нөхөн төлүүлэлт 2017 онд 64,8 хувь, 2018 онд 100 хувь болжээ.

Хүснэгт 2.10. “Хүчдгийн эсрэг гэмт хэрэг” бүлгийн хохирол нөхөн төлүүлэлт

Зүйл анги	Бүртгэгдсэн гэмт хэрэг		Хохирсон бүгд		Хохирлын мөнгөн дүн		Нөхөн төлүүлсэн хохирол		Битүүмжилсэн хөрөнгө	
	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018
16.1	6	2	5	2	500,000	2,000,000	500,000	2,000,000	0	0
16.2	0	0	0	0	0	0	0	0	0	0
16.3	15	6	9	6	1,000,000	400,000	1,000,000	300,000	8,000,000	0
16.5	0	0	0	0	0	0	0	0	0	0
16.7	3	4	1	3	0	1,000,000	0	0	0	0
16.8	0	8	0	6	0	100,000	0	0	0	0
16.11	106	1	113	1	59,839,800	500,000	38,289,800	0	7,500,000	0
Нийт	130	21	128	18	61,339,800	4,000,000	39,789,800	2,300,000	15,500,000	0

Эрүүгийн хуулийн арван зургаадугаар бүлгийн хэргүүд дотроос 16.11 дүгээр зүйл “Хүүхдийг асран хамгаалах үүргээ үл биелүүлэх” гэмт хэргийн улмаас хохирч байгаа хүүхдийн тоо бүлгийн бусад гэмт хэргүүдээ бодвол 2017 онд илүү өндөр байсан боловч 2018 онд эрс буурч зөвхөн 1 хэрэг бүртгэгджээ. Мөн Хүүхдийг асран хамгаалах үүргээ үл биелүүлэх гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлт 2017 онд 64 хувьтай байна.

2.3.8. Эрүүгийн хуулийн арван долоодугаар бүлэг “Өмчлөх эрхийн эсрэг” гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлтийн талаарх статистик

Улсын хэмжээнд 2017 онд Эрүүгийн хуулийн арван долоодугаар бүлгийн гэмт хэрэг 18,416 бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 23,548 хүн, 39 хуулийн этгээд буюу нийт 23,587 хүн, хуулийн этгээд хохирсон байна. Нийт хохирсон иргэдийн 54.7 хувь буюу 12,770 нь эмэгтэй байжээ. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн улмаас 2 хүүхэд нас барж, 230 хүн гэмтсэн байна. Гэмт хэргийн улмаас 161,718,956,358 төгрөгийн хохирол учирч 58,497,919,018 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж 28,435,924,436 төгрөгийн эд хөрөнгийг битүүмжлэх ажиллагаа хийгдсэн бөгөөд 2017 онд “Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг” бүлгийн хохирол нөхөн төлөлт 36.1 хувьтай байна.

2018 онд энэ төрлийн гэмт хэрэг 22,468 бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 20,845 хүн, 26 хуулийн этгээд буюу нийт 20,871 хүн, хуулийн этгээд хохирсны 46.3 хувь буюу 9,648 нь эмэгтэй байжээ. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн улмаас 94 хүн гэмтсэн байна. Энэ төрлийн гэмт хэргийн улмаас 139,316,345,118 төгрөгийн хохирол учирч 19,509,929,200 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, 2,258,236,348 төгрөгийн эд хөрөнгийг битүүмжлэх ажиллагаа хийгджээ. 2018 онд тус бүлгийн гэмт хэргийн хохирол төлөлт 14 хувьтай байжээ. “Өмчлөх эрхийн эсрэг” гэмт хэрэг бүлгийн хохирол нөхөн төлүүлэлтийн байдал 2018 онд өмнөх онтой харьцуулахад 22.3 хувиар буурсан байна.

*Хүснэгт 2.11. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн
хохирол нөхөн төлүүлэлт*

Зүйл анги	Бүртгэгдсэн гэмт хэрэг		Хохирсон бүгд		Хохирлын мөнгөн дүн	
	2017 он	2018 он	2017 он	2018 он	2017 он	2018 он
17.1	12,222	12,328	11,395	11,570	16,648,758,844	19,368,308,332
17.2	1,233	1,497	1,062	1,392	947,126,054	1,263,894,438
17.3	2,996	5,372	9,275	4,918	123,178,553,792	103,901,012,533
17.4	369	562	343	433	6,542,861,509	6,929,473,845
17.5	432	1,160	346	1,031	327,076,642	1,318,994,157
17.6	26	17	23	15	11,142,467,000	933,380,000
17.7	31	80	29	78	66,612,700	574,308,000
17.8	187	329	160	302	342,236,907	713,589,796
17.9	4	2	7	1	2,980,000	700,000
17.10	3	4	3	3	124,200,000	183,000,000
17.11	12	21	9	21	10,432,300	388,990,492
17.12	901	1,096	935	1,107	2,385,650,610	3,740,693,525
Нийт	18,416	22,468	23,587	20,871	161,718,956,358	139,316,345,118
Үүнээс						
Зүйл анги	Нөхөн төлүүлсэн хохирол		Битүүмжилсэн хөрөнгө			
	2017 он	2018 он	2017 он	2018 он		
17.1	5,145,145,979	4,074,124,687	572,490,011	469,800,507		
17.2	401,107,050	186,551,100	27,761,658	12,900,000		
17.3	48,403,551,598	11,227,218,713	2,655,588,8721	758,650,005		
17.4	2,569,540,449	938,623,675	132,126,000	7,660,027		
17.5	65,390,532	272,063,792	21,600,000	22,675,801		
17.6	839,370,000	921,500,000	600,000,000	633,000,000		
17.7	26,790,000	204,054,000	0	11,450,000		
17.8	80,048,160	120,195,257	18,100,000	28,150,000		
17.9	0	0	8,000,000	0		
17.10	1,200,000	0	15,000,000	0		
17.11	2,300,000	267,914,196	0	0		
17.12	963,475,250	1,297,683,780	484,958,046	313,950,008		
Нийт	58,497,919,018	19,509,929,200	28,435,924,436	2,258,236,348		

Энэ төрлийн гэмт хэргээс Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйл буюу “Хулгайлах” гэмт хэргийн улмаас 2017 онд 11,395 хүн, хуулийн этгээдэд 16,648,758,844 төгрөгийн хохирол учирч 30.9 хувь буюу 5,145,145,979 төгрөгийн хохирол нөхөн төлөгджээ. Харин 2018 онд 11,570 хүн, хуулийн этгээдэд 19,368,308,332 төгрөгийн хохирол учирч 21 хувь буюу 4,074,124,687 төгрөгийн хохирол нөхөн төлөгдсөн байна.

Эрүүгийн хуулийн 17.2 дугаар зүйл. “Дээрэмдэх” гэмт хэргийн улмаас 2017 онд 1,233 хүн, хуулийн этгээдэд 947,126,054 төгрөгийн хохирол учирч 42.4 хувь буюу 401,107,050 төгрөгийн хохирол нөхөн төлөгдсөн бол 2018 онд уг гэмт хэргийн улмаас 1,392 хүн, хуулийн этгээдэд 1,263,894,438 төгрөгийн хохирол учирч 14.8 хувь буюу 186,551,100 төгрөгийн хохирол нөхөн төлөгдсөн байна.

Эрүүгийн хуулийн 17.3 дугаар зүйл. “Залилах” гэмт хэргийн улмаас 2017 онд 9,275 хүн, хуулийн этгээдэд 123,178,553,792 төгрөгийн хохирол учирч 39.3 хувь буюу 48,403,551,598 төгрөгийн хохирол нөхөн төлөгдсөн байна. 2018 онд уг гэмт хэргийн улмаас 4,914 хүн хуулийн этгээдэд 103,901,012,533 төгрөгийн хохирол учирч 10.8 хувь буюу 11,227,218,713 төгрөгийн хохирол нөхөн төлөгджээ.

Тус бүлгийн хамгийн түгээмэл үйлдэгдсэн хулгайлах, дээрэмдэх, залилах гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлтийг дунджаар авч үзвэл 2017 онд 37,5 хувь, 2018 онд 15,5 хувь болж 22 пунктээр буурчээ. Эндээс дүгнэхэд иргэн, хуулийн этгээдэд хамгийн их хохирол учруулж байгаа өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлт туйлын хангалтгүй байна.²⁰

²⁰ Өмчлөх эрхийн эсрэг бүлгийн гэмт хэргүүд дотроос 17.1 дүгээр зүйл “Хулгайлах”, 17.2 дугаар зүйл “Дээрэмдэх”, 17.3 дугаар зүйл “Залилах” гэмт хэргүүдийн хохирол нөхөн төлүүлэлтийн нөхцөл байдлыг хавтаст хэрэгт дүн шинжилгээ хийх замаар судлан гаргаж ирэхээр сонгон авсан болно.

2.3.9. Эрүүгийн хуулийн арван наймдугаар бүлэг “Эдийн засгийн” гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлтийн талаарх статистик

Улсын хэмжээнд 2017 онд Эрүүгийн хуулийн арван наймдугаар бүлгийн гэмт хэрэг 294 бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 88 хүн, 20 хуулийн этгээд буюу нийт 108 хүн, хуулийн этгээд хохирсон байна. Нийт хохирсон иргэний 70.4 хувь буюу 62 нь эмэгтэй байжээ. Уг гэмт хэргийн улмаас 10,142,433,831 төгрөгийн хохирол учирч 542,962,700 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, 114,830,002 төгрөгийн эд хөрөнгийг битүүмжлэх ажиллагаа хийгджээ.

2018 онд энэ төрлийн гэмт хэрэг 242 бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 131 хүн, 13 хуулийн этгээд буюу нийт 144 хүн, хуулийн этгээд хохирсон байна. Хохирсон иргэдийн 49.6 хувь буюу 65 нь эмэгтэй байжээ. Дээрх гэмт хэргийн улмаас 23,033,800,948 төгрөгийн хохирол учирч 1,197,031,204 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, 70,850,005 төгрөгийн эд хөрөнгийг битүүмжлэх ажиллагаа хийгджээ. Эдийн засгийн эсрэг гэмт хэрэг бүлгийн хохирол нөхөн төлүүлэлтийн байдал 2017 онд 5.6 хувьтай байсан бол 2018 онд 5.2 хувьтай байна.

Хүснэгт 2.12. Эдийн засгийн гэмт хэргийн хохирол нөхөн төлөгдсөн нөхцөл байдал

Зүйл анги	Бүртгэгдсэн гэмт хэрэг		Хохирсон бүгд		Хохирлын мөнгөн дүн	
	2017 он	2018 он	2017 он	2018 он	2017 он	2018 он
18.1	1	1	0	0	0	0
18.2	0	0	0	0	0	0
18.3	29	23	2	14	767,282,181	19,712,022,723
18.4	2	4	2	4	900,000	2,250,000
18.5	79	53	31	23	822,693,200	235,823,306
18.6	2	24	0	5	0	2,624,438,700
18.7	169	120	63	74	215,664,450	382,538,839
18.8	1	0	1	0	18,500	0
18.9	0	0	1	0	18,500	0
18.10	0	0	1	0	18,500	0
18.11	0	0	1	0	18,500	0
18.12	2	6	1	6	3,820,000	55,227,380
18.13	4	1	3	0	8,330,000,000	0
18.14	0	1	0	1	0	5,000,000
18.15	2	1	0	0	0	5,000,000
18.16	3	4	2	3	2,000,000	11,500,000
18.17	0	4	0	1	0	0
18.18	0	0	0	0	0	0
нийт	294	242	108	131	10,142,433,831	23,033,800,948
Үүнээс						
Зүйл анги	Нөхөн төлүүлсэн хохирол		Битүүмжилсэн хөрөнгө			
	2017 он	2018 он	2017 он	2018 он		
18.1	Хохирол нөхөн төлүүлсэн, хөрөнгө битүүмжилсэн тохиолдол байхгүй.					
18.2	Хохирол нөхөн төлүүлсэн, хөрөнгө битүүмжилсэн тохиолдол байхгүй.					
18.3	0	590,549,998	0	0		
18.4	0	0	0	0		
18.5	299,212,700	225,720,806	113,330,002	70,780,005		
18.6		361,850,000		0		
18.7	209,930,000	6,250,000	1,500,000	0		
18.8-18.11	Хохирол нөхөн төлүүлсэн, хөрөнгө битүүмжилсэн тохиолдол байхгүй.					
18.12	3,820,000	12,660,400	0	70,000		
18.13	30,000,000	0	0	0		
18.14-18.18	Хохирол нөхөн төлүүлсэн, хөрөнгө битүүмжилсэн тохиолдол байхгүй.					
Нийт	542,962,700	1,197,031,204	114,830,002	70,850,005		

Эрүүгийн хуулийн арван наймдугаар бүлэг “Эдийн засгийн гэмт хэрэг” бүлгийн хэргүүд дотроос 18.7 дугаар зүйл буюу “Мөнгөн тэмдэгт, үнэт цаас, төлбөр тооцооны хэрэгсэл хуурамчаар бэлтгэх, ашиглах” гэмт хэргийн улмаас 2017 онд 63 хүн, хуулийн этгээдэд 215,664,450 төгрөгийн хохирол учирч 97.3 хувь буюу 209,930,000 төгрөгийн хохирол нөхөн төлөгдсөн бол 2018 онд 74 хүн, хуулийн этгээдэд 382,538,839 төгрөгийн хохирол учирч 1.6 хувь буюу 6,250,000 төгрөгийн хохирол нөхөн төлөгдсөн байна. “Мөнгөн тэмдэгт, үнэт цаас, төлбөр тооцооны хэрэгсэл хуурамчаар бэлтгэх, ашиглах” гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлт 2017 онтой харьцуулахад 95.7 хувиар буурчээ.

2.3.10. Эрүүгийн хуулийн арван есдүгээр бүлэг Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлтийн талаарх статистик

Энэ төрлийн гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлтийн талаарх статистик мэдээлэл бүртгэгдээгүй байна.

2.3.11. Эрүүгийн хуулийн хорьдугаар бүлэг “Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг” гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлтийн талаарх статистик

Улсын хэмжээнд 2017 онд Эрүүгийн хуулийн хорьдугаар бүлгийн гэмт хэрэг 1,077 бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 975 хүн, хуулийн этгээд хохирсон байна. Хохирсон иргэдийн 23.7 хувь буюу 254 нь эмэгтэй байжээ. Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэргийн улмаас 3 хүн нас барж, 801 хүн гэмтжээ. Уг гэмт хэргийн улмаас иргэн, хуулийн этгээдэд 1,931,734,537 төгрөгийн хохирол учирч 1,619,676,587 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, 574,268,001 төгрөгийн эд хөрөнгийг битүүмжлэх ажиллагаа хийгдсэн байна.

2018 онд энэ төрлийн гэмт хэрэг 314 бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 93 хүн, 4 хуулийн этгээд буюу нийт 97 хүн, хуулийн этгээд хохирчээ. Нийт хохирсон иргэний 28 (30.1 хувь) нь эмэгтэй байжээ. Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэргийн улмаас 44 хүн гэмтсэн байна. Гэмт хэргийн улмаас 552,544,485 төгрөгийн хохирол учирч 99,140,485 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, 681,261,000 төгрөгийн эд хөрөнгийг битүүмжлэх ажиллагаа хийгджээ.

Хүснэгт 2.13. Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлт

Зүйл анги	Бүртгэгдсэн гэмт хэрэг		Хохирсон бүгд		Хохирлын мөнгөн дүн	
	2017 он	2018 он	2017 он	2018 он	2017 он	2018 он
20.1	2	0	1	0	200,000	0
20.2	0	0	1	0	200,000	0
20.3	3	0	1	0	200,000	0
20.4	4	11	2	5	330,000	36,895,400
20.5	6	0	2	0	500,000	0
20.6	2	1	2	1	4,000,000	0
20.7	128	195	5	3	600,000	500,000
20.8	3	1	0	0	0	0
20.9	1	3	0	1	0	500,000
20.10	0	1	0	0	0	0
20.11	0	0	0	0	0	0
20.12	0	3	0	2	0	5,000,000
20.13	2	16	2	9	0	425,550,000
20.14	21	14	11	12	10,357,587	29,845,085
20.15	160	11	160	11	100,170,500	9,100,000
20.16	745	58	788	53	1,816,406,450	45,154,000
Нийт	1077	314	975	97	1,932,964,537	552,544,485

Зүйл анги	Үүнээс			
	Нөхөн төлүүлсэн хохирол		Битүүмжилсэн хөрөнгө	
	2017 он	2018 он	2017 он	2018 он
20.1	200,000	0	0	0
20.2	200,000	0	0	0
20.3	200,000	0	0	0
20.4	200,000	36,895,400	0	660,000
20.5	500,000	0	9,000,000	0
20.6	0	0	0	0
20.7	0	0	410,500,001	210,000,000
20.8	0	0	0	0
20.9	0	500,000	0	0
20.10	0	0	0	0
20.11	0	0	0	0
20.12	0	0	0	70,000,000
20.13	0	0	0	6,500,000,000
20.14	10,007,587	29,845,085	1,200,000	26,000,000
20.15	93,050,500	8,000,000	8,180,000	0
20.16	1,515,318,500	23,900,000	145,388,000	5,950,000
Нийт	1,619,676,587	99,140,485	574,268,001	6,812,610,000

Тус бүлгийн гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлт 2017 онд 83.8 хувьтай байсан бол 2018 онд 17.9 болж 65.9 пунктээр буурчээ. Эрүүгийн хуулийн хорьдугаар бүлгийн хэргүүд дотроос 20.16 дугаар зүйл буюу “Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах” гэмт хэргийн улмаас 2017 онд 788 хүн, хуулийн этгээдэд 1,816,406,450 төгрөгийн хохирол учирч 83.4 хувь буюу 1,515,318,500 төгрөгийн хохирол нөхөн төлөгдсөн бол, 2018 онд 53 хүн, хуулийн этгээдэд 45,154,000 төгрөгийн хохирол учирч учирсан хохирлын 52.9 хувь буюу 23,900,000 төгрөгийн хохирол нөхөн төлөгдсөн байна.

2.3.12. Эрүүгийн хуулийн хорин нэгдүгээр бүлэг “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг” гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлтийн талаарх статистик

Улсын хэмжээнд 2018 онд Эрүүгийн хуулийн хорин нэгдүгээр бүлгийн гэмт хэрэг 112 бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 76 хүн, 1 хуулийн этгээд нийт 77 хүн, хуулийн этгээд хохирчээ. Хохирсон иргэдийн 48.7 хувь буюу 37 нь эмэгтэй байжээ. Уг бүлгийн гэмт хэргийн улмаас 1 хүн нас барж, 6 хүн гэмтжээ. Гэмт хэргийн улмаас 984,158,842 төгрөгийн хохирол учирч 85,426,900 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, 500,000 төгрөгийн эд хөрөнгийг битүүмжлэх ажиллагаа хийгдсэн байна.

2018 онд энэ төрлийн гэмт хэрэг 196 бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас нийт 82 хүн хохирсон байна. Нийт хохирсон иргэний 37.8 хувь буюу 31 нь эмэгтэй хүн байжээ. Дээрх бүлгийн гэмт хэргүүдийн улмаас 945,872,703 төгрөгийн хохирол учирч 130,799,000 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, 14,300,000 төгрөгийн эд хөрөнгийг битүүмжлэх ажиллагаа хийгджээ.

Хүснэгт 2.14. Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлт

Зүйл анги	Бүртгэгдсэн гэмт хэрэг		Хохирсон бүгд		Хохирлын мөнгөн дүн	
	2017 он	2018 он	2017 он	2018 он	2017 он	2018 он
21.1	17	51	12	20	22,500,000	303,609,453
21.2	8	27	4	8	40,000,000	9,099,000
21.3	8	2	0	2	0	0
21.4	6	13	4	8	32,621,000	25,000,000
21.5		5	0	1		0
21.7	47	58	28	37	864,255,794	585,164,250
21.8	0	1	0	1	0	3,000,000
21.9	0		0	0	0	0
21.10	14	6	4	3	6,402,848	20,000,000
21.11	6	5	11	1	6,859,200	0
21.12	2	24	0	0	0	0
21.13	2	3	1	0	2,880,000	0
21.14	2	1	1	1	2,880,000	0
21.15	0	0	1	0	2,880,000	0
21.16	0	0	1	0	2,880,000	0
Нийт	112	196	77	82	984,158,842	945,872,703
Үүнээс						
Зүйл анги	Нөхөн төлүүлсэн хохирол		Битүүмжилсэн хөрөнгө			
	2017 он	2018 он	2017 он	2018 он		
21.1	1,000,000	0	0	0		
21.2	40,000,000	4,099,000	0	300,000		
21.3	0	0	0	0		
21.4	2,500,000	0	0	0		
21.5	0	0	0	0		
21.7	32,954,000	106,700,000	0	14,000,000		
21.8	0	0	0	0		
21.9	0	0	0	0		
21.10	2,426,900	20,000,000	0	0		
21.11	6,546,000	0	500,000	0		
21.12-21.16	Нөхөн төлүүлсэн хохирол, битүүмжилсэн хөрөнгө байхгүй.					
Нийт	85,426,900	130,799,000	500,000	14,300,000		

Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг бүлгийн хохирол нөхөн төлүүлэлтийн байдал 2017 онд 8.6 хувь, 2018 онд 13.8 хувьтай байгаагаас үзвэл хохирол нөхөн төлүүлэлт хангалтгүй байна. Эрүүгийн хуулийн хорин нэгдүгээр бүлгийн хэргүүд дотроос 21.7 дугаар зүйл буюу “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулах, зайлсхийх” гэмт хэргийн улмаас 2017 онд 28 хүнд 864,255,794 төгрөгийн хохирол учирч 3.8 хувь буюу 32,954,000 төгрөгийн хохирол нөхөн төлөгдсөн бол, 2018 онд 37 хүнд 585,164,250 төгрөгийн хохирол учирч учирсан хохирлын 18.2 хувь буюу 106,700,000 төгрөгийн хохирол нөхөн төлөгджээ.

2.3.13. Эрүүгийн хуулийн хорин хоёрдугаар бүлэг “Авлигын” гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлтийн талаарх статистик

Улсын хэмжээнд 2018 онд Эрүүгийн хуулийн хорин хоёрдугаар бүлгийн гэмт хэргийн улмаас 13 хүн, 2 хуулийн этгээд буюу нийт 15 хүн, хуулийн этгээд хохирсон байна. Нийт хохирогчдын 61.5 хувь буюу 8 нь эмэгтэй хүн байжээ. Дээрх гэмт хэргийн улмаас 494,643,370 төгрөгийн хохирол учирч 75,343,370 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн байна. Хохирол нөхөн төлүүлэлттэй холбоотой эд хөрөнгө битүүмжлэх ажиллагаа хийгдээгүй.

2018 онд энэ төрлийн гэмт хэргийн улмаас 5 хүн, 3 хуулийн этгээд нийт 8 хүн, хуулийн этгээд хохирсноос, хохирогчид бүгд эмэгтэй хүн байжээ. Дээрх гэмт хэргийн улмаас 162,948,400 төгрөгийн хохирол учирчээ. Хохирол нөхөн төлүүлэлттэй холбоотой эд хөрөнгө битүүмжлэх ажиллагаа хийгдээгүй байна. Энэ төрлийн гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлт 2017 онд 15.2 хувь, 2018 онд 13.8 хувьтай байгаагаас үзвэл хохирол нөхөн төлүүлэлт хангалтгүй байна.

*Хүснэгт 2.15. “Авлигын гэмт хэрэг” бүлгийн
хохирол нөхөн төлүүлэлт*

Зүйл анги	Бүртгэгдсэн гэмт хэрэг		Хохирсон бүгд		Хохирлын мөнгөн дүн	
	2017 он	2018 он	2017 он	2018 он	2017 он	2018 он
22.1	82	269	5	6	89,793,370	142,610,400
22.2	0	0	5	0	0	0
22.3	0	0	5	0	0	0
22.4	27	58	0	0	0	0
22.5	5	9	0	1	0	0
22.6	Бүртгэгдсэн гэмт хэрэг байхгүй.					
22.7	Бүртгэгдсэн гэмт хэрэг байхгүй.					
22.8	8	10	1	0	4,000,000	0
22.9	3	4	0	1	0	20,338,000
22.10	2	5	0	0	0	0
22.11	2	0	1	0	850,000	0
22.12	6	7	1	0	400,000,000	0
Нийт	150	362	15	8	494,643,370	162,948,400
Үүнээс						
Зүйл анги	Нөхөн төлүүлсэн хохирол		Битүүмжилсэн хөрөнгө			
	2017 он	2018 он	2017 он	2018 он	2017 он	2018 он
22.1	75,343,370	0	0	0	0	0
22.2- 22.12	Нөхөн төлүүлсэн хохирол, битүүмжилсэн хөрөнгө байхгүй.					

Жич: Гэмт хэргийн статистик мэдээллийг гаргахдаа хэрэг бүртгэлтийн хэргийн тоог бүртгэгдсэн гэмт хэргийн тоо гэж үзэж байсан тул бүртгэгдсэн гэмт хэрэг болон хохирогч нарын тоо илт зөрүүтэй гарсан болно.

Дээрх хүснэгтээс харвал, Эрүүгийн хуулийн хорин хоёрдугаар бүлгийн гэмт хэргийн улмаас 2017 онд 15 хүн, хуулийн этгээдэд 533,639,670 төгрөгийн хохирол учирч түүнээс 20.9 хувь нь буюу 111,520,370 төгрөгийн хохирол нөхөн төлөгджээ. 2018 оны хувьд 8 хүн, хуулийн этгээдэд учирсан 162,948,400 төгрөгийн хохирол нөхөн төлөгдсөн эсэх нь тодорхойгүй байна.

2.3.14. Хорин гуравдугаар бүлэг “Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг” гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлтийн талаарх статистик

Улсын хэмжээнд 2017 онд “Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг” буюу хорин гуравдугаар бүлгийн гэмт хэрэг 262 бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 199 хүн, 6 хуулийн этгээд буюу нийт 205 хүн, хуулийн этгээд хохирсон байна. Хохирсон иргэний 26.6 хувь буюу 53 нь эмэгтэй байжээ. Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэргийн улмаас 55 хүн гэмтсэн. Дээрх гэмт хэргийн улмаас 2,048,764,650 төгрөгийн хохирол учирч 1,263,010,350 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, 1,765,707,309 төгрөгийн эд хөрөнгийг битүүмжлэх ажиллагаа хийгдсэн байна.

2018 онд дээрх бүлгийн гэмт хэрэг 237 бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 170 хүн, 3 хуулийн этгээд буюу нийт 173 хүн, хуулийн этгээд хохирсон байна. Нийт хохирсон иргэдийн 27.0 хувь буюу 46 нь эмэгтэй байжээ. Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэргийн улмаас 55 хүн гэмтсэн байна. Гэмт хэргийн улмаас 12,157,768,535 төгрөгийн хохирол учирч 119,116,000 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, 35,950,001 төгрөгийн эд хөрөнгийг битүүмжлэх ажиллагаа хийгджээ.

Дээрх бүлгийн гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлтийн байдал 2017 онд 61.6 хувьтай байсан бол 2018 онд 0.9 хувьтай болж өмнөх оноос 60.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 2.16. Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлт

Зүйл анги	Бүртгэгдсэн гэмт хэрэг		Хохирсон бүгд		Хохирлын мөнгөн дүн	
	2017 он	2018 он	2017 он	2018 он	2017 он	2018 он
23.1	89	85	96	83	51,050,000	53,438,000
23.2	128	137	78	80	1,938,911,050	11,723,430,535
23.3	3	8	3	4	4,469,100	1,800,000
23.4	0	0	3	4	4,469,100	1,800,000
23.5	5	5	3	4	4,469,100	1,800,000
23.6	0	0	7	4	45,396,300	379,000,000
23.7	0	2		2	0	100,000
Нийт	262	237	205	173	2,048,764,650	12,161,368,535
Үүнээс						
Зүйл анги	Нөхөн төлүүлсэн хохирол		Битүүмжилсэн хөрөнгө			
	2017 он	2018 он	2017 он	2018 он		
23.1	44,780,000	38,175,000	72,107,302	23,350,001		
23.2	1,168,746,050	80,141,000	1,693,600,007	12,600,000		
23.3	4,469,100	800,000	0	0		
23.4	4,469,100	800,000	0	0		
23.5	4,469,100	800,000	0	0		
23.6	36,077,000	0	0	0		
23.7	0	0	0	0		
Нийт	1,263,010,350	120,716,000	1,765,707,309	35,950,001		

Дээрх хүснэгтээс харвал, Эрүүгийн хуулийн хорин гуравдугаар бүлгийн гэмт хэргүүдийн улмаас 2017 онд 205 хүн, хуулийн этгээдэд 2,170,230,150 төгрөгийн хохирол учирч 61.9 хувь буюу 1,342,845,150 төгрөгийн хохирол нөхөн төлөгдсөн бол, 2018 онд 173 хүн, хуулийн этгээдэд 12,157,768,535 төгрөгийн хохирол учирч 0.9 хувь буюу 119,116,000 төгрөгийн хохирол нөхөн төлөгджээ.

2.3.15. Эрүүгийн хуулийн хорин дөрөвдүгээр бүлэг “Хүрээлэн байгаа орчны эсрэг” гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлтийн талаарх статистик

Улсын хэмжээнд 2017 онд Эрүүгийн хуулийн хорин дөрөвдүгээр бүлгийн гэмт хэрэг 330 бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 229 хүн, 14 хуулийн этгээд буюу нийт 243 хүн, хуулийн этгээд хохирсон байна. Нийт хохирогчдын 26,6 хувь буюу 61 нь эмэгтэй байжээ. Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн улмаас 2 хүн гэмтжээ. Дээрх гэмт хэргийн улмаас 4,352,392,971 төгрөгийн хохирол учирч 1,202,475,784 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, 1,911,380,963 төгрөгийн эд хөрөнгийг битүүмжлэх ажиллагаа хийгдсэн байна.

2018 онд дээрх бүлгийн гэмт хэрэг 366 бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 305 хүн, 8 хуулийн этгээд буюу нийт 313 хүн, хуулийн этгээд хохирсон байна. Хохирогчдын 25.6 хувь буюу 78 нь эмэгтэй байжээ. Дээрх бүлгийн гэмт хэргийн улмаас 2 хүн гэмтсэн байна. Гэмт хэргийн улмаас 2,557,291,933 төгрөгийн хохирол учирч 1,062,763,266 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, 1,176,847,090 төгрөгийн эд хөрөнгийг битүүмжлэх ажиллагаа хийгджээ.

Дээрх бүлгийн гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлтийн байдал 2017 онд 27.6 хувьтай байсан бол 2018 онд 41.5 хувьтай буюу өмнөх оноос 13.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 2.17. “Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг” бүлгийн хохирол нөхөн төлөгдсөн нөхцөл байдал

Зүйл анги	Бүртгэгдсэн гэмт хэрэг		Хохирсон бүгд		Хохирлын мөнгөн дүн	
	2017 он	2018 он	2017 он	2018 он	2017 он	2018 он
24.1	6	5	6	2	148,889,181	200,000
24.2	104	126	64	114	734,879,174	676,340,654
24.3	7	15	3	5	318,363	9,400,000
24.4	0	0	3	0	318,363	9,400,000
24.5	0	32	33	29	592,493,000	177,415,000
24.6	42	163	105	145	242,212,503	649,612,202
24.7	128	7	6	7	1,933,632,000	937,252,648
24.8	7	15	22	9	508,818,750	107,071,429
24.9	28	3	1	2	10,000,000	0
Нийт	322	366	243	313	4,352,392,971	2,557,291,933

Үүнээс

Зүйл анги	Нөхөн төлүүлсэн хохирол		Битүүмжилсэн хөрөнгө	
	2017 он	2018 он	2017 он	2018 он
23.1	30,634,500	200,000	12,000,000	0
23.2	443,600,790	410,315,945	731,964,478	391,250,000
23.3	318,363	9,400,000	210,000,000	795
23.4	318,363	9,400,000	210,000,000	795
23.5	272,193,000	124,915,000	218,800,002	83,700,000
23.6	141,369,881	410,860,892	325,676,308	647,746,295
23.7	480,000	0	0	0
24.8	313,879,250	107,071,429	38,400,175	54,150,000
24.9	0	0	0	0
Нийт	1,202,475,784	1,062,763,266	1,911,380,963	1,176,847,090

Жич: Дээр дурдсанчлан цагдаагийн байгууллага гэмт хэргийн статистик мэдээллийг гаргахдаа хэрэг бүртгэлтийн хэргийн тоог бүртгэгдсэн гэмт хэргийн тоо гэж үзэж байсан тул бүртгэгдсэн гэмт хэрэг болон хохирогч нарын тоо таарахгүй илт зөрүүтэй гарсан болно.

Дээрх хүснэгтээс харвал, Эрүүгийн хуулийн хорин дөрөвдүгээр бүлгийн гэмт хэргийн улмаас 2017 онд 243 хүн, хуулийн этгээдэд учирсан 4,352,392,971 төгрөгийн хохирлоос 27.6 хувь буюу 1,202,475,784 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн бол 2018 онд иргэн хуулийн этгээдэд учирсан 2,557,291,933 төгрөгийн хохирлоос 41.5 хувь буюу 1,062,763,266 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн байна.

2.3.16. Эрүүгийн хуулийн хорин тавдугаар бүлэг “Соёлын өвийн эсрэг” гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлтийн талаарх статистик

Энэ бүлгийн гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлтийн талаарх мэдээлэл бүртгэгдээгүй байна.

2.3.17. Эрүүгийн хуулийн хорин зургаадугаар бүлэг “Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг” гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлтийн талаарх статистик

Улсын хэмжээнд 2017 онд Эрүүгийн хуулийн хорин зургаадугаар бүлгийн гэмт хэрэг 39 бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас нийт 10 хүн хохирсноос 6 (60 хувь) нь эмэгтэй байжээ. Дээрх бүлгийн гэмт хэргийн улмаас 11,158,284 төгрөгийн хохирол учирч 5,000,000 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн бөгөөд хохирол нөхөн төлүүлэлттэй холбоотой эд хөрөнгө битүүмжлэх ажиллагаа хийгдээгүй байна.

2018 онд дээрх бүлгийн гэмт хэрэг 42 бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас нийт 24 хүн хохирсноос 8 (33.3 хувь) нь эмэгтэй байжээ. Дээрх бүлгийн гэмт хэргийн улмаас 440,944,000 төгрөгийн хохирол учирч 2,900,000 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн байна. Хохирол нөхөн төлүүлэлттэй холбоотой эд хөрөнгө битүүмжлэх ажиллагаа хийгдээгүй.

Дээрх бүлгийн гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлтийн байдал 2017 онд 44.8 хувьтай байсан бол 2018 онд 0.6 хувь буюу өмнөх оноос 44.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 2.18. “Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг” бүлгийн хохирол нөхөн төлөгдсөн нөхцөл байдал

Зүйл анги	Бүртгэгдсэн гэмт хэрэг		Хохирсон бүгд		Хохирлын мөнгөн дүн		Нөхөн төлүүлсэн хохирол		Битүүмжилсэн хөрөнгө	
	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018
26.1	38	41	9	23	11,158,284	430,944,000	5,000,000	2,900,000	0	0
26.2	1	1	1	1	0	10,000,000	0	0	0	0
26.3	0	0	0	0	0	0	0	0	0	0
Нийт	39	42	10	24	11,158,284	440,944,000	5,000,000	2,900,000	0	0

Дээрх хүснэгтээс харахад, Эрүүгийн хуулийн хорин зургаадугаар бүлгийн гэмт хэргүүдийн улмаас 2017 онд 10 хүн, хуулийн этгээдэд учирсан 11,158,284 төгрөгийн хохирлоос 44.8 хувь буюу 5,000,000 төгрөгийн хохирол нөхөн төлөгдсөн бол, 2018 онд 24 хүн, хуулийн этгээдэд учирсан 440,944,000 төгрөгийн хохирлоос 0.6 хувь буюу 2,900,000 төгрөгийн хохирол нөхөн төлөгджээ.

**2.3.18. Эрүүгийн хуулийн хорин долоодугаар бүлэг
“Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн
ашиглалтын журмын эсрэг” гэмт хэргийн хохирол
нөхөн төлүүлэлтийн талаарх статистик**

Улсын хэмжээнд 2017 онд “Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг” бүлгийн гэмт хэрэг 1,525 бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас нийт 1,728 хүн хохирчээ. Нийт хохирогчдын 38.9 хувь буюу 673 нь эмэгтэй, 3.2 хувь буюу 55 нь насанд хүрээгүй хүүхэд байжээ. Уг бүлгийн гэмт хэргийн улмаас 392 хүн нас барж, 1,135 хүн гэмтжээ. Гэмт хэргийн улмаас 5,316,113,416 төгрөгийн хохирол учирч 4,148,125,520 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, 1,863,750,665 төгрөгийн эд хөрөнгийг битүүмжлэх ажиллагаа хийгдсэн байна.

2018 онд дээрх бүлгийн гэмт хэрэг 1,231 бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 1,375 хүн хохирсон байна. Нийт хохирогчдын 43 хувь буюу 592 нь эмэгтэй, 14 хувь буюу 192 нь насанд хүрээгүй хүүхэд байжээ. Дээрх бүлгийн гэмт хэргийн улмаас 325 хүн нас барж, 998 хүн гэмтсэн байна. Гэмт хэргийн улмаас 4,612,204,315 төгрөгийн хохирол учирч 3,386,299,921 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, 1,021,060,006 төгрөгийн эд хөрөнгийг битүүмжлэх ажиллагаа хийгджээ.

Хүснэгт 2.19. “Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг” бүлгийн хохирол нөхөн төлөгдсөн нөхцөл байдал

Зүйл анги	Бүртгэгдсэн гэмт хэрэг		Хохирсон бүгд		Хохирлын мөнгөн дүн	
	2017	2018	2017	2018	2017	2018
27.1	1	2	1	2	0	250,000
27.3	5	3	4	3	87,228,727	35,052,124
27.10	1,291	1,215	1,490	1,359	4,821,239,249	4,567,802,191
27.11	198	11	204	11	338,140,940	9,100,000
Нийт	1,525	1,231	1,728	1,375	5,246,608,916	4,612,204,315
Үүнээс						
Зүйл анги	Нөхөн төлүүлсэн хохирол		Битүүмжилсэн хөрөнгө			
	2017 он	2018 он	2017 он	2018 он		
27.1	0	250,000	0	0		
27.3	87,228,727	0	10,000,000	0		
27.10	3,717,844,653	3,383,549,921	1,509,259,457	1,007,560,006		
27.11	285,246,140	2,500,000	335,824,705	13,500,000		
Нийт	4,090,319,520	3,386,299,921	1,855,084,162	1,021,060,006		

Жич: Дээр дурдсанчлан цагдаагийн байгууллага гэмт хэргийн статистик мэдээллийг гаргахдаа хэрэг бүртгэлтийн хэргийн тоог бүртгэгдсэн гэмт хэргийн тоо гэж үзэж байсан тул бүртгэгдсэн гэмт хэрэг болон хохирогч нарын тоо таарахгүй илт зөрүүтэй гарсан болно.

Дээрх хүснэгтээс харахад, Эрүүгийн хуулийн хорин долоодугаар бүлгийн гэмт хэргүүдийн улмаас 2017 онд 1,728 хүн, хуулийн этгээдэд учирсан 5,316,113,416 төгрөгийн хохирлоос 78 хувь буюу 4,148,125,520 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн бол 2018 онд 1,375 хүн, хуулийн этгээдэд учирсан 4,612,204,315 сая төгрөгийн

хохирлоос 73.4 хувь буюу 3,386,299,921 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн байна.²¹

2.3.19. Эрүүгийн хуулийн хорин наймдугаар бүлэг
“Цэргийн албаны эсрэг” гэмт хэргийн хохирол нөхөн
төлүүлэлтийн талаарх статистик

Улсын хэмжээнд 2017 онд “Цэргийн албаны эсрэг” бүлгийн гэмт хэрэг 5 бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас нийт 13 хүн хохирсон байна. Дээрх бүлгийн гэмт хэргийн улмаас 47,000,000 төгрөгийн хохирол учирч 8,000,000 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлжээ. Хохирол нөхөн төлүүлэлттэй холбоотой эд хөрөнгө битүүмжлэх ажиллагаа хийгдээгүй.

2018 онд дээрх бүлгийн гэмт хэрэг 15 бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас нийт 13 хүн хохирсон байна. Дээрх бүлгийн гэмт хэргийн улмаас 13,850,000 төгрөгийн хохирол учирч 10,850,000 төгрөгийн хохирлыг нөхөн төлж 1,800,000 төгрөгийн эд хөрөнгийг битүүмжлэх ажиллагаа хийгджээ.

²¹ Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг бүлгийн гэмт хэргүүд дотроос 27.10 дугаар зүйл “Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих” гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлтийн нөхцөл байдлыг хавтаст хэрэгт дүн шинжилгээ хийх замаар судлан гаргаж ирэхээр сонгон авсан болно.

Хүснэгт 2.20. “Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг” бүлгийн хохирол нөхөн төлөгдсөн нөхцөл байдал

Зүйл анги	Бүртгэгдсэн гэмт хэрэг		Хохирол бүгд		Хохирлын мөнгөн дүн		Нөхөн төлүүлсэн хохирол		Битүүмжилсэн хөрөнгө	
	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018
28.3	2	2	2	2	2,000,000	2,000,000	2,000,000	0	0	0
28.5	1	11	1	9	3,000,000	1,850,000	3,000,000	850,000	0	1,800,000
28.6	0	0	0	0	0	0	0	0	0	0
28.9	2	2	10	2	42,000,000	10,000,000	3,000,000	10,000,000	0	0
Нийт	5	15	13	13	47,000,000	13,850,000	8,000,000	10,850,000	0	1,800,000

Дээрх хүснэгтээс харахад, Эрүүгийн хуулийн хорин наймдугаар бүлгийн гэмт хэргийн улмаас 2017 онд 13 хүнд 47,000,000 төгрөгийн хохирол учирч 17 хувь буюу 8,000,000 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн бол 2018 онд 13,850,000 төгрөгийн хохирол учирч 78.3 хувь буюу 10,850,000 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлжээ.²²

2.3.20. Эрүүгийн хуулийн хорин есдүгээр бүлэг “Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг” гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлтийн талаарх статистик

Энэ бүлгийн гэмт хэрэг 2017 болон 2018 онд ЦЕГ-т бүртгэгдээгүй байна.

²² ЦЕГ-ын мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны статистик мэдээллийн албанаас ирүүлсэн тоон мэдээ, Гэмт хэргийн цагаан ном 2017, 2018

2.4. ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОЛ, ХОР УРШГИЙГ ТОГТООЖ, НӨХӨН ТӨЛҮҮЛСЭН БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Судалгааны хүрээнд судлаачдын боловсруулсан асуумжийн дагуу түгээмэл үйлдэгддэг 10 төрлийн хэрэгт хохирол, хор уршгийн хэмжээг тогтоож, үнэлж, түүнийг нөхөн барагдуулж байгаа байдалд дүн шинжилгээ хийлээ. Энэ хүрээнд 2017 оны 7 дугаар сарын 1-ээс хойш шийдвэрлэгдсэн нийт 509 хэргийг хамруулсан болно.

Хүснэгт 2.21. “Хавтаст хэргийн судалгаа”-ны хүрээнд судалсан хэргийн тоо

№	Гэмт хэргийн төрөл	Судалсан хэргийн тоо
1	Хүнийг алах	40
2	Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах	26
3	Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах	24
4	Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах	100
5	Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг	20
6	Хүчиндэх гэмт хэрэг	19
7	Хулгайлах гэмт хэрэг	150
8	Дээрэмдэх	50
9	Залилах	50
10	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	30
Нийт 509 хэрэг		

2.4.1. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын төрөл, хэмжээг тогтоож, үнэлж буй байдал

Дээр дурдсан 10 төрлийн гэмт хэрэгт хохирол, хор уршгийг үнэлж, тогтоож байгаа байдал харилцан адилгүй байсан бөгөөд энэ нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хохирол, уршгийн хэмжээг тогтоох, үнэлэх нэгдсэн аргачлал байхгүйгээс хохирогчийн мэдүүлэг, хохирогчоос гаргаж өгсөн баримт, сэлтийг

нотлох баримтад үнэлэх, эд зүйлийн үнэлгээ хийлгэх, эмнэлгийн болон бусад шаардлагатай үйл баримтыг үнэлэх замаар тогтоож байна.

1. Хөрөнгийн хохирол, хор уршиг (эдийн болон эдийн бус)

Гэмт хэргийн хохирлын талаар 2002 оноос хойш хийгдсэн судалгаатай харьцуулбал, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт хохирлын хэмжээ тогтоох мөрдөгчийн арга барил хэвээр төдийгүй прокурор, шүүх эд зүйлийн үнэлгээ хийх шалтгаанаар хэрэг буцаадаг нөхцөл байдал хэвээр байна. Эрүүгийн хуулийн 2.5 дугаар зүйлд заасан шүүх цугларсан нотлох баримтад үндэслэн хохирол, хор уршигийн хэмжээг мөнгөн дүнгээр эцэслэн тогтоох зохицуулалтын дагуу шийдвэрлэсэн 3 тохиолдол л байна. Түүнчлэн Баянзүрх дүүргийн шүүхээс нийт 5 хэрэгт “мөрдөгчийн магадалгаа” гаргаж хохирлын хэмжээг тогтоосныг нотлох баримтаар үнэлж шийдвэрлэжээ. Бусад бүх тохиолдолд эд зүйлийн үнэлгээ хийлгэж хохирлын хэмжээг тогтоожээ.

Эд хөрөнгийн хохирлын хэмжээг хэрхэн тогтоож буй талаар эрүүгийн хэргийн материалыг судлахад ихэвчлэн “Хөрөнгийн үнэлгээний комисс” гэх субъект үнэлгээ тогтоож байна. Тус комисс дараах хүснэгтийг ашиглан үнэлгээ тогтоодог өмнөх соёл, хандлага хэвээр бөгөөд Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд заасан хөрөнгийн үнэлгээ хийх эрх бүхий этгээд үнэлгээг хийж байна.

Хүснэгт 2.22. Хохирлын үнэлгээ хийх хүснэгт

Батлав..... МБА-ны дарга.....

№	Эд зүйлийн нэр	Чанар байдлын тодорхойлолт	Үнэлгээ			Тайлбар
			Хохирогчийн	Шалгаж буй газрын	Үнэлгээ хийж буй албан тушаалтны	

Дээрх хүснэгтийн дагуу аймаг, дүүргийн Хөрөнгийн үнэлгээний комисс (Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд заасан) үнэлгээг тогтоодог бөгөөд судалсан хэргүүдийн тухайд тус комисс үндсэн ажил үүргийнхээ хажуугаар энэ ажлыг хийдэг бөгөөд эд зүйл үнэлэхэд мэргэшил, мэдлэг шаарддаггүй. Тиймээс үнэлгээ тогтоож буй дээрх комисс нь эд хөрөнгийн шинж чанарыг тогтоолгүйгээр үнэлж буй нь хохирлын үнэлгээг бодитой, зөв хийж буй гэдэгт эргэлзээ төрүүлж байгаа юм. Өөрөөр хэлбэл, эд хөрөнгийг үнэлэх тогтсон аргачлал байхгүй. Тухайлбал, хулгайд алдагдсан гар утсыг үнэлэхдээ хохирогчийн үнэлгээнээс 100,000-200,000 төгрөгөөр бууруулж үнэлсэн атлаа яагаад ийнхүү бууруулан үнэлэх болсноо тайлбарладаггүй.

Жишээ 1: Хэргийн товч утга: 2017 оны 2 дугаар сарын 21-ний өдөр Сонгинохайрхан дүүргийн 29 дүгээр хороо “ZTB” шүдний эмнэлэгт цйлчлүүлж байсан иргэн “Д”-гийн халааснаас түрийвчтэй бичиг баримт, бэлэн мөнгө болон виза картаас мөнгө авсан гэх хэрэгт.²³ Алдсан бэлэн мөнгө болон виза картаас авсан мөнгийг хохиролд тооцож, үнэлсэн ч бичиг баримт, виза карт зэргийг сэргээлгэх, нөхөн гаргуулах зардлыг тооцож үнэлээгүй байна.

Эд зүйлийг үнэлэх ажиллагаа Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд заасан Хөрөнгийг үнэлэх журмын дагуу хийгдэхгүй буюу үнэлгээ хийж буй албан тушаалтан өөрийн үзэмжээр үнэлгээ хийж, хохирогчийн үнийн саналаас ихэнхдээ бууруулан үнэлж хэвшсэн бөгөөд ийнхүү бууруулан үнэлсэн талаараа тайлбар хийдэггүй нь хохирлын хэмжээг бодит бусаар тогтоох, улмаар хохирогчийг нэмж хохироход хүргэж байна. Дээрх хүснэгтээр үнэлгээ хийх тухай 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд огт байхгүй бөгөөд дээрх хүснэгт нь анх Нийслэлийн АДХ-ын 1993 оны “Эрүү, иргэний хэрэгт үнэлгээ хийлгэх тухай” тогтоолд тусгагдаж, хавтаст хэрэгт заавал байх нэг нотлох баримт болж ирсэн байна.

²³ 2017.10.13 Шийтгэх тогтоолын дугаар 447.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох зүйл, хэсэг заалтыг үзвэл²⁴ хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий эд зүйлийн шинж байдал, үнэд хамаарах баримт сэлтийг мөрдөгч бэхжүүлэн, нотлох баримт болгох, шаардлагатай гэж үзвэл мөрдөгчийн магадалгаа, шинжээчийн дүгнэлтээр тогтоолгохоор заасан.

Мөрдөгч Б.Б. “Хуулийн анхны үзэл санааг сургалтаар тайлбарлахад бид тухайн хулгайлагдсан эсхүл дээрэмдүцлсэн эд зүйлийн анх авсан үнэ, эдэлгээ, шинж байдлыг баримтаар тогтоогоод хэргийг шилжүүлж үзсэн ч “заавал үнэлгээ хийлгэ” гэж хэрэг буцаадаг, энэ тохиолдолд бид өмнө байсан эд зүйлийн үнэлгээ хийлгэх хуудсыг ашиглаж байгаа хэвээрээ. Орон нутагт бол байдал илүү хүнд, өөрөөр хэлбэл хөрөнгийн үнэлгээчин байхгүй тул өмнө үйлчилж байсан хуулийн²⁵ дагуу Засаг даргын тамгын газрын Санхүцгийн мэргэжилтэн болон бусад этгээдээр хийлгэж байгаа.

.... дүцргийн орлогч прокурор Б.Ц Эрүцргийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу эд зүйлийн үнэлгээ гэх хуучин ойлголтоос аль болох татгалзахыг хичээж байгаа, бидний зүгээс “мөрдөгчийн магадалгаа” гаргаж өмчлөх эрхийн эсрэг хэрэгт хохирлын хэмжээг тогтоож эхэлсэн, шүүх ч үүнийг боломжтой гэж үнэлж, шийдвэрлэж эхлээд байна. Бусад дүцрэгт бол энэ практик харилцан адилгүй байгаа гэж сонссон.

Судалгааны явцад гэр бүлийн хамаарал бүхий хүний эсрэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт эвдэж гэмтээсэн эд хөрөнгөд үнэлгээ хийлгээгүй 5 хэрэг байсан бөгөөд ямар шалтгаанаар дээрх хохирлыг үнэлээгүй нь тодорхойгүй. Мөн хоорондоо танил талын харилцаатай хүний эсрэг үйлдэгдсэн өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт илэрхий хохирол учирсан байтал хохирогчийн гомдол, саналгүй, учирсан хохиролгүй хэмээх мэдүүлэгт үндэслэн

²⁴ Эрх зүйн орчин хэсгээс үзнэ үү.

²⁵ 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хууль үйлчилж байхад үнэлгээ хийж байсан субъект

бэхжүүлж шийдвэрлэжээ. Энэ мэтээр гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг бодитой тогтоодоггүй байдал хэвээр байна.

Дээрх байдлаас үзвэл, хөрөнгийн хохирлыг үнэлэх арга харилцан адилгүй байгаа бөгөөд энэ нь мөрдөгчийн сургалтаар олж авсан мэдлэг, хандлага, тухайн харьяалах орон нутгийн прокурор, шүүхийн практиктай шууд холбоотой гэж дүгнэхэд хүрлээ.

2. Эрүүл мэндийн хохирол, хор уршиг

Эрүүгийн эрх зүйн шинэтгэлийн үйл явц, шинээр батлагдсан хууль тогтоомжийн үзэл баримтлалыг авч үзэхэд, хүний эрүүл мэндийн хохирлыг бие махбодын болон сэтгэл санааны хохирол хэмээн ангилан тогтоож, мөнгөн хэлбэрээр үнэлэхээр зохицуулжээ. Хэдий тийм ч судалгааны явцад Шүүхийн шинжилгээний хүрээлэнгийн даргын баталсан “Хүний биед учирсан гэмтлийн зэрэг тогтоох заавар”-ын агуулга өөрчлөгдөөгүй, сэтгэл санааны хохирлыг үнэлэх нэгдсэн аргачлал батлаагүй хэвээр байна.

Судалгааны хүрээнд хүний эрүүл мэндэд хөнгөн, хүндэвтэр, хүнд хохирол санаатай учруулсан хэргийг түүвэрлэн судлахад хохирогчийн нэхэмжилсэн хэмжээгээр, эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн зардлаар, гэмтлийн зэрэг тогтоосон шинжээчийн дүгнэлтээр, эсхүл цаашид гарах эмчилгээний зардлыг тооцсоноор гаргасан байх бөгөөд зарим хэрэгт эрүүл мэндэд учирсан хохирлыг тооцож, үнэлээгүй байсан.²⁶

Тухайлбал, гэр бүлийн хүчирхийллийн 5 гэмт хэргийн хувьд болж өнгөрсөн үйл баримтыг нотлох боломжгүй байсны улмаас хохирогч олон жилийн турш байнга гэр бүлийн хүчирхийлэлд байснаар эрүүл мэндэд нь ямар хохирол учирсныг тогтоож чадаагүй байна. Шалгаж шийдсэн нэг хэрэгт сэтгэл зүйн хувьд хохирсон гэж мэдүүлсэн ч хохирлоо мөнгөн хэлбэрээр үнэлж нэхэмжлээгүй, шүүх эмнэлэгт үзүүлсэн, эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн зэрэг үйл

²⁶ Хүнийг алах, Хүний эрүүл мэндэд хохирол учруулах хэрэгт хийсэн судалгааны дэд тайлангаас дэлгэрүүлж үзэх

баримтад үндэслэн мөнгөн дүнг тогтоожээ. Харин хор уршгийг үнэлсэн нэг л тохиолдол байна. Хор уршгийг ажилгүй байсан хугацааны цалингаар тогтоосон бөгөөд 3 сарын цалин буюу нийт 1,780,000 төгрөгөөр бодож тооцжээ. Үлдсэн хоёр хэрэгт хохирогч хохирлоо нэхэмжлээгүй бөгөөд хохирол тогтоох талаар ямар нэг ажиллагаа хийгдээгүй байна.

Хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулсан хэрэгт шинжилгээ хийхэд 10 хохирогч буюу нийт хохирогчийн 38,4 хувь нь мэдүүлгээр, 5 буюу 19.3 хувь нь баримтаар, 4 буюу 15.4 хувь нь эмчилгээний зардлаар, 3.8 хувь нь иргэний нэхэмжлэлээр тус тус хохирлыг үнэлж тогтоожээ.²⁷ Үлдсэн 2 хүн буюу 7,7 хувь нь хохирол нэхэмжлээгүй, 4 хүн буюу 15.4 хувьд нь хохирол тогтоох ажиллагаа хийгдээгүй байна. Хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулсан хэрэгт ихэвчлэн хохирогчийн мэдүүлэгт үндэслэн хохирлыг үнэлжээ. Эрүүл мэндийн хохирол, хор уршгийг ялган тогтоох ажиллагаа нийт судлагдсан хэргийн тухайд тун хангалтгүй байсан бөгөөд гэмт хэргийн хор уршгийг иргэний эрх зүйн гэм хортой хутган ойлгож, шүүхийн шийдвэртээ тухайн хор уршгийг иргэний журмаар нэхэмжлэх эрхтэй болохыг дурдаж шийджээ. Судалсан хэрэгт авагдсан баримтаас үзэхэд иргэний эрх зүйн гэм хор гэж үзсэн хэргийн оролцогчдоос гаргасан нотлох баримт нь гэмт хэргийн хор уршиг байж болох үндэслэлтэй байна.

Тухайлбал, Хүнийг алах гэмт хэргийг шийдвэрлэсэн 2 тохиолдолд хууль ёсны төлөөлөгчид нь сэтгэл санааны хохирол, тэжээгчээ алдсаны тэтгэмжийг нэхэмжилсэн ч шүүхийн зүгээс иргэний хуулийг удирдлага болгон шийдвэрлэж, нэхэмжлэх эрхийг дурджээ. Үндсэндээ хүнийг алах гэмт хэргийн шууд хохирлыг оршуулгын зардал төдийгөөр хэмжиж ирсэн практик өөрчлөгдөөгүй байгаа нь судалгааны явцад ажиглагдлаа.

²⁷ Судалгааны түүврийн хүрээнд нийт 26 хавтаст хэрэгт асуумжийн дагуу хийсэн судалгаа

Мөн “Тээврийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг”-т дээрх нөхцөл өөрөөр ажиглагдаж байгаа бөгөөд хохирлын үнэлгээг тогтоохдоо эмчилгээ хийлгэсэн зардал 32.6 хувь, хохирогчийн мэдүүлэг 30.3 хувь, шинжээчийн дүгнэлт 23.6 хувь, эд зүйлийн үнэлгээ 5.6 хувь, иргэний нэхэмжлэл 4.5 хувийг тус тус үндэслэл болгож байгаа бөгөөд эдгээр нь нэхэмжлэлийн 96.6 хувийг эзэлж байна. Энэ гэмт хэргийн гол онцлог нь эд хөрөнгө болон эрүүл мэндэд давхар хохирол учирдаг онцлогтой. Бусад гэмт хэргийг бодвол хохирлын хэмжээг тогтоох, үнэлэх тал дээр харьцангуй эерэг үзүүлэлттэй байсныг тэмдэглэх нь зүйтэй.

Хүний эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн шийдвэрлэлтээс үзвэл хохирогчдын нэг хэсэг нь гэмтэл авсан эд эрхтнээ өөрсдийн үзэмжээр үнэлж, чанартай улсын болон хувийн эмнэлгүүдээр явж эмчилгээ хийлгэн холбогдох нотлох баримтуудыг цуглуулан өгч, тэр хэмжээгээрээ хохирлоо гаргуулан авч чадаж байгаа бол, нөгөө хэсэг нь хохирлоо хэрхэн яаж гаргуулах, баримтуудыг хэрхэн яаж бүрдүүлэх талаар мэдлэг дутмаг, зөвхөн эмчилгээний зардлаа л нэхэмжилж, хохирлоо бага хэмжээний мөнгөн дүнгээр төлүүлэн хоцорч байна. Өөрөөр хэлбэл, эрүүл мэндэд учирсан хохирлын жишиг үнэлгээ байхгүй тул хэн эмчилгээ хийлгэж, баримт цуглуулж чадсан нь хохирлоо тогтоолгодог практик тогтжээ.

Мөрдөгч, прокурор нь зөвхөн гэмт хэрэг үйлдсэн хүний гэм буруутай үйлдлийг тогтоох, нотлоход анхаардаг бөгөөд тухайн гэмт хэргийн улмаас учирсан хохирол, тэр дундаа сэтгэл санааны хохирлыг үнэлэх, барагдуулах асуудлыг анхаарч үзэхгүй хэвээр байна. Харин шүүх хавтаст хэргийн хүрээнд, хуульд заасан нотлох баримтын шаардлага хангасан, бодит баримтад тулгуурлан хохирлыг үнэлдэг тул сэтгэл санааны хохирлыг шийдвэрлэхгүй орхигдуулах нь түгээмэл байна. Судалгааны үр дүнгээс харахад гэмт хэргийн улмаас хохирсон иргэний сэтгэл санааны хохирол буюу эдийн бус хохирлыг огт шийдвэрлэхгүй, иргэний хэргийн журмаар шүүхэд нэхэмжлэл гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй болохыг шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолд дурддаг практик

тогтсон бөгөөд сэтгэл санааны хохирлыг мөнгөөр үнэлэх аргачлал, эрх зүйн зохицуулалт байхгүйн улмаас иргэний хэргийн шүүх хохирлыг нөхөн төлүүлдэггүй байдал хэвээр байна. Эндээс дүгнэхэд өмнөх ЭБШХ-иар хэрэг шийдвэрлэдэг байсан практик өөрчлөгдсөнгүй гэж дүгнэлээ.

2.4.2. Шүүхээс гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг шийдвэрлэж буй байдал

Мөрдөгчөөс шалгаж, прокуророос хянаж ирүүлсэн хэргийг шүүх ердийн болон хялбаршуулсан журмаар шийдвэрлэхдээ Эрүүгийн хуулийн 2.5 дугаар зүйлд заасны дагуу хэрэгт авагдсан хохирлын үнэлгээ, түүнд хамаарах нотлох баримт, гэрч, хохирогчийн мэдүүлэг зэргийг үнэлсний дүнд гэмт хэргийн хохирол, хор уршгийг тодорхойлж, нийт мөнгөн дүнг тодорхойлох ёстой. Судалсан эрүүгийн хэрэгт дурдагдсан хор уршгийг иргэний эрх зүйн гэм хор гэж үзэх явдал түгээмэл байсан төдийгүй зарим тохиолдолд зөвхөн хохирогчийн мэдүүлэг нотлох баримт болж чадахгүй тул нэхэмжилсэн мөнгөн дүнг үндэслэлгүй хэмээн шийдвэрлэжээ.

Судалсан шүүхийн шийдвэрийн 87 хувьд зөвхөн гэмт хэргийн хохирлыг мөнгөн дүнгээр тооцож, гаргуулахаар шийдвэрлэсэн бол гэмт хэргийн хохирол, хор уршгийг ялгамжтай тооцсон тохиолдол 11 хэрэгт л байгаа нь туйлын хангалтгүй үзүүлэлт юм. Өөрөөр хэлбэл, мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хавтаст хэргийг шүүх шийдвэрлэхдээ хохирол, хор уршгийг ялгахгүй байгаа дүр зураг ажиглагдлаа.

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн хувьд ижил нэр төрлийн, ижил үнэтэй эд зүйлийг хэт ялгамжтай байдлаар үнэлж байгаа нь судалгааны явцад ажиглагдсан. Хэрэгт авагдсан нотлох баримтаар тухайн эд зүйлийн хохирлын хэмжээг шүүх мөнгөн дүнгээр тогтоох боломжтой атал судалгаанд хамрагдсан хулгайлах, дээрэмдэх гэмт хэргийн 12 хувийг “үнэлгээ хийлгэ” гэсэн шалтгаанаар мөрдөн байцаалтад буцаажээ. Мөрдөгч, прокурор нь зөвхөн гэмт

хэрэг үйлдсэн хүний гэм буруутай үйлдлийг л тогтоох, нотлоход анхаардаг бөгөөд тухайн хэргийн улмаас учирсан хохирлыг шалган тогтоосон байдал, хохирогчийн хөдөлмөр эрхлэлтийн байдал, өрхийн сарын дундаж орлого, амьжиргааны түвшин зэргийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад огт шалгадаггүй, прокурор болон шүүхээс мөн адил энэ асуудлыг хөнддөггүй болох нь тогтоогдлоо.

Хүний эрүүл мэндэд учирсан хохиролтой холбоотойгоор эд эрхтнийг үнэлж тооцон хохирлыг барагдуулах заавар, дүрэм, журмыг шинэчлэн батлаагүй тул эрүүл мэндийн хохирлыг хохирогчийн мэдүүлгээр буюу талууд харилцан тохиролцсон бол шууд тэр дүнгээр тогтоож байна. Эрүүгийн хуулийн 6.7, 7.1 дэх зүйлд заасан үндэслэл, журмын дагуу гэмт хэргийн хохирол, хор уршгаа нөхөн төлсөн байх эсхүл нөхөн төлөхөө илэрхийлсэн тохиолдолд үзүүлэх тодорхой хөнгөлөлтийн дагуу зөвхөн хохирогчийн гаргаж өгсөн баримт сэлт, мэдүүлэгт үндэслэн хохирол, хор уршгийн хэмжээг тогтоож байна.²⁸

Талууд хохирлын асуудлаар харилцан тохиролцоогүй тохиолдолд шүүх хавтаст хэрэгт цугларсан шаардлага хангасан нотлох баримтыг үнэлж хохирлын мөнгөн дүнг тооцож байна. Хохирогч амьдралын боломжоос шалтгаалан эмчилгээ хийлгэж чадаагүй, цаашид эмчилгээ хийлгэх шаардлагатай тул эмчилгээний зардлын мөнгөн дүнг нэхэмжилдэг ч шүүх шийдвэрлэхдээ зөвхөн хэрэгт авагдсан баримтад тулгуурлан эмчилгээний зардлын мөнгөн дүнг олгож байгаа тул цаашид гарах эмчилгээний зардлыг шийдвэрлэлгүй, харин иргэний журмаар жич нэхэмжлэх эрхтэйг дурдан шийдэж байна. Энэ нь төлбөрийн чадваргүй хохирогчдын хувьд хүнд тусдаг ажээ. Ялангуяа яаралтай эмчилгээ хийлгэж чадаагүйн улмаас хөгжлийн бэрхшээлтэй болох ч эрсдэл байна.

²⁸ Шүүхээс хэргийг хянан шийдвэрлэхдээ хохирол нөхөн төлүүлэлттэй холбоотой хохирогч гомдол саналгүй, шүүгдэгчийн зүгээс хохирлыг барагдуулсан гэснийг үндэслэн, шүүгдэгчийн хохирогчид хэдий хэмжээний мөнгөн дүнг, ямар нотлох баримтад тулгуурлан олгож байгаа эсэхийг огт хяналгүй шийдвэрлэжээ.

Зарим хохирогчийн хувьд эдийн засаг, санхүүгийн боломжгүй байдлаас шалтгаалан эрүүл мэнддээ хөнгөн, хүндэвтэр, хүнд гэмтэл авсан тохиолдолд бага хэмжээтэй эмчилгээний зардал гаргуулж шийдвэрлүүлж байхад санхүүгийн хувьд боломжтой зарим хэсэг нь гадаад улсад болон хувийн эмнэлэгт өртөг өндөртэй эмчилгээ хийлгэж, баримтыг нотлох баримтад тооцуулах замаар гэмт хэргийн хохирол, хор уршгаа шүүхээр илүү бодитой үнэлүүлж, тогтоолгуулжээ.

Нотлох баримтгүй бол хохирлыг үнэлэх боломжгүй учир ар гэрийн бололцоо муутай хохирогч мөрдөн шалгах ажиллагааны шатанд болон шүүхийн шатанд бодит баримт гаргаж өгч чаддаггүй байдлаасаа болоод хохирлоо нэхэмжилж чаддаггүй. Ийнхүү гэмт хэргийн улмаас эрүүл мэндэд хохирол учирсан талаар үйл баримт сэлт, нэхэмжлэлийг нотлох баримтаар тооцох хэмжээнд гаргаж өгөөгүй тохиолдолд шүүх шүүгдэгчийг бусдад төлөх төлбөргүй хэмээн шийдэж байна. Энэ нь Монгол Улсын Үндсэн хууль болон Эрүүгийн хуульд заасан хохирогчийн эрхийн баталгаа шударгаар хангагдахгүй байгааг харуулж байгаа юм.

Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүмүүсийн дунд гэмт хэрэг үйлдэгдсэн тохиолдолд хохирогч нэхэмжлэл гаргахгүй, хохирлын мөнгөн дүн тодорхойгүй, мөрдөгч, прокурор, шүүгчийн зүгээс ч хохирлын асуудлыг шалгаж, шийдвэрлэдэггүй жишиг тогтжээ.

2.4.3. Гэмт хэргийн хохирол, хор уршигтай холбогдуулан гаргасан иргэний нэхэмжлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал

Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн холбогдох зохицуулалтыг үзвэл иргэний нэхэмжлэгч нь гэмт хэргийн улмаас гэм хор учирсан гуравдагч этгээд байхаар зохицуулсан бөгөөд эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн өмнө бүх хохирогчийг иргэний нэхэмжлэгчээр давхар тогтоодог байсан.

Энэ үед хохирогчийн тоо иргэний нэхэмжлэгчийн тоотой тэнцүү байсан бөгөөд шинэ хууль үйлчилж эхэлснээс хойш энэ тоо тав дахин буурчээ.

Хэдий тийм ч судлагдсан 10 төрлийн хэрэгт гэмт хэргийн хор уршгийг иргэний эрх зүйн гэм хор гэж үзэж иргэний журмаар нэхэмжлэх эрхийг дурдсан тохиолдол нийт шийдвэрийн 65 хувийг эзэлж байгаа нь шинэ зохицуулалтыг шүүх нэг мөр хэрэгжүүлэхгүй байгааг харуулж байна.

Гэмт хэргийн улмаас амь насанд учирсан хохирлыг иргэний хуулиар хэрхэн зохицуулж байгааг судалж тогтоохын тулд Иргэний хэргийн шүүхээр Иргэний хуулийн 497, 508 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэсэн 7 шийтгэх тогтоолд дүн шинжилгээ хийлээ. Хохирогч нас барснаас учирсан гэм хорыг арилгах нэхэмжлэлийн шаардлагатай 5 хэргийн хувьд тэжээгчээ алдсаны тэтгэмж гаргуулахтай холбоотой 2, амь хохирогчийн авсан байсан зээлийг төлүүлэхтэй холбоотой 1, амь хохирогчийг амьд байсан бол олох орлого, цалин хөлсийг нэхэмжилсэн 1, хариуцагчийн гэм бурууг эрүүгийн хэргийн шүүхээр тогтоохтой холбоотой хот руу ирэхэд гарсан зардлыг нэхэмжилсэн 1 хэрэг тус тус байна.

Иргэний хэргийн шүүх гэмт хэргийн улмаас учирсан хохирол барагдуулахтай холбоотой хэргийг шийдвэрлэхдээ нотлох баримтад тулгуурлаж буюу баримтаар тогтоогдсон мөнгөн дүнг л нэхэмжлэгч нарт олгохоор шийджээ. Сэтгэл санааны хохирол болон баримт байхгүй ч нэхэмжлэгчид зайлшгүй шаардлагатай мөнгө буюу тухайлбал, эмчилгээний зардал зэргийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэжээ.

Жишээ 2: Хүнийг алах гэмт хэрэг: Нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн 143 дугаартай хэргийн хувьд холбогдох нотлох баримтыг хангалттай цуглуулсан байсан тул хуулийн дагуу буюу нас барсан хохирогчийн 18 нас хүрээгүй хүчхдэд сар бүр 250,000 төгрөгийг шүүгдэгчээс гаргуулан олгохоор шийдвэрлэжээ. ... дугаартай өөр нэг хэргийн хувьд цугларсан нотлох баримтад үндэслэн нэхэмжлэлийн мөнгөн дүнд өөрчлөлт оруулж буюу 1,204,736 төгрөгийн хохирлыг шүүгдэгчээс нөхөн төлүүлэхээр шийдвэрлэсэн байна. Хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн 3 хэргийн хувьд хуулийн дагуу бүрдүүлэх ёстой нотлох баримтыг бүрдүүлж чадаагүй байх тул нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгон шийдвэрлэжээ.

Хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэргийн иргэний нэхэмжлэлтэй холбоотой нийт судалсан 62 шийтгэх тогтоолын 13 буюу 20.9 хувь нь “Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах”, 7 буюу 11.3 хувь нь “Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол учруулах”, 14 буюу 22.6 хувь нь “Хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулах”, 22 буюу 35.5 хувь нь “Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих”, 6 буюу 9.7 хувь нь “Бусад” төрлийн гэмт хэргийн улмаас хохирсон иргэд байх бөгөөд иргэний хэргийн шүүхэд хохирлоо барагдуулахаар нэхэмжлэл гаргажээ.

Гэмт хэргийн улмаас бусдын эрүүл мэндэд учирсан хохирлыг арилгах нэхэмжлэлтэй иргэний хэргийн 66 шийтгэх тогтоолын 9 буюу 13.7 хувийг нэхэмжлэгчийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож, 10 буюу 15.1 хувийг нэхэмжлэгчийн шаардлагыг бүхэлд нь хангаж, 47 буюу 71.2 хувийг нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж, үлдсэнийг нь хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн байна.

Жишээ 3: 195 тогтоолын дугаартай иргэний хэрэг Гэм хорын хохирол 164,812,451 төгрөг гаргуулах нэхэмжлэлтэй. Хариуцагч нэхэмжлэгчийг зодож бие махбодод нь хүнд хохирол санаатай учруулсан. Эмчилгээний зардал, олох байсан орлого, цалин, хөдөлмөрийн хөлсний зөрцү, сэтгэл санааны хохирол болон бусад зардлыг нэхэмжилсэн байна. Шүцхийн зүгээс ИХ-ийн 497.1, 505.1-ийг тус тус баримтлан нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж буюу 11,558,792 төгрөгийг гаргуулахаар шийдвэрлэсэн бол сувиллын үйл ажиллагаа явуулах эрхгүй байгуулагаар сувилуулсан зардлыг хариуцагчаас гаргуулан нэхэмжлэгчид олгох үндэслэлгүй, мөн иргэний хуульд сэтгэл санааны хохирлыг зохицуулаагүй гэсэн үндэслэлээр 153,253,659 төгрөгийг буюу үлдсэнийг нь хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн байна.


Иргэний хэргийн шүүхийн шийдвэрт хийсэн судалгаанаас үзвэл, гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссанаар болон бусад үндэслэлээр хэрэгсэхгүй болсон эсхүл эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрт иргэний журмаар нэхэмжлэл гаргах эрхтэй болохыг дурдсаныг үндэслэж шүүхэд нэхэмжлэл гаргажээ. Иргэний хэргийн шүүх нэхэмжлэлийг шийдвэрлэхдээ оролцогч талуудын гаргаж өгсөн нотлох баримтын хүрээнд шийдвэрлэсэн байх бөгөөд шаардлага хангахгүй нотлох баримтыг хэлэлцэхгүй орхиж, нэхэмжлэлийн шаардлагын багахан хэсгийг хангаж шийдвэрлэжээ.

2.4.4. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг нөхөн төлүүлсэн байдал

Шинэчлэн найруулсан Монгол Улсын Эрүүгийн хууль хэрэгжиж эхэлсэн 2017 онд уг хуулийг шинэчлэхэд баримталсан шударга ёсыг сэргээн тогтоох үзэл санаа амжилттай хэрэгжиж гэмт хэргийн улмаас учирсан хохирлын мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх хэмжээ 198.1 тэрбум төгрөгөөр тогтоогдож, дээрх хохирлоос 74.5 тэрбум төгрөг буюу 36.7 хувийг нөхөн төлүүлжээ. 2018 онд гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ 193.3 тэрбум төгрөг

буюу өмнөх онтойгоо бараг ижил хэмжээний хохирол тогтоосон атал хохирол нөхөн төлүүлэлт дөнгөж 32.4 тэрбум буюу 16.8 хувийг нөхөн төлүүлж, гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлт эрс буурчээ.

График 2.6. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол (2017-2018 онд сая.төг)



Эрүүгийн хуулийн хэрэгжилтийн явцад хохирол нөхөн төлүүлэлт 2017 онд 37.6 хувь байсан бол 2018 онд хохирол 16.8 хувь буюу 20.8 хувиар буурсан нь Эрүүгийн хуулийн хөнгөн ангиллын 50 гэмт хэрэгт хорих ял биш бусад төрлийн ялыг оногдуулж байгаагаас үүдэн хохирол барагдуулалттай холбогдуулан ял шийтгэлийг хөнгөрүүлэх, чөлөөлөх боломжгүй болсноос үүдэн хохирол барагдуулалт буурчээ. Үүнийг судалгаанд хамрагдсан улсын яллагч, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид хөндсөн болно.

Ялын үндсэн шинж болох хохирол, хор уршгаа барагдуулсан тохиолдолд тэнсэх зохицуулалтыг цаашид илүү тодорхой болгохгүй бол гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлөх явдал буурах хандлагатай байна. Судалгааны тайлан бичих явцад дээрх хуулийн зохицуулалтыг 2020 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр Эрүүгийн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр засжээ.

Гэмт хэрэг тус бүрийн хохирол нөхөн төлүүлэлтийн статистикийг харвал, “Хүнийг алах” гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлт 2017 онд 60.2 хувь, 2018 онд 76.9 хувьтай байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт бол “Эдийн засгийн эсрэг гэмт хэрэг” бүлгийн хохирол нөхөн төлүүлэлтийн байдал 2017 онд 5.6 хувьтай байсан бол 2018 онд 5.2 хувьтай байгаа нь хамгийн бага үзүүлэлт болно.

2002 оны Эрүүгийн хуульд байсан зарим зүйл анги 2015 оны эрүүгийн хуулиас хасагдсан, эсхүл өөр гэмт хэргийн шинжид хамаарч өөрчлөгдсөн, мөн шинэ төрлийн гэмт хэргийг хуульчилсан тул 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн Эрүүгийн хуулийн зүйл ангиудыг 2002 оны Эрүүгийн хуулийн ижил төстэй гэмт хэргийн шинжтэй жишиж 2017 оны гэмт хэргийн статистик мэдээллийг гаргасан тул гэмт хэргийн хохирлын зарим тоон мэдээ зөрж байгаа болно.

Зарим гэмт хэргийн хувьд бүртгэгдсэн хэргийн тооноос хохирогчийн тоо бага байгаа шалтгаан нь ЭХХШТХ-д заасан “Хэрэг бүртгэлт” гэх ойлголтоос хамаарч байна. Өөрөөр хэлбэл, ЭХХШТХ-ийн 30.7 дугаар зүйлийн “Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг шалгах” хойшлуулшгүй ажиллагааны 1.3-т “гэрчээс мэдүүлэг авах” гэж хуульчилж өгсөнтэй холбоотойгоор хохирогчийг тогтоох, хохирогчоор байцаах эрх зүйн зохицуулалт байхгүй болж, хохирогчийг гэрчээр тооцож мэдүүлэг авдаг болсонтой холбоотой.

Цагдаагийн байгууллага гэмт хэргийн статистик, тоо мэдээг гаргахдаа зарим хэргийн хохирогчийг тогтоож амжаагүй байхад тухайн бүртгэгдсэн хэрэг бүртгэлтийн хэргийн мэдээг санд оруулдаг, үүнээс болоод хэргийн тоо их мөртөө хохирогчийн тоо бага гарах нөхцөл үүсдэг хэмээн Прокурорын байгууллагын гэмт хэргийн бүртгэл, судалгаа хариуцсан нэгж тайлбарласан болно. Харин 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр дээрх хуулийн зохицуулалтад нэмэлт өөрчлөлт орж “хохирогч, гэрчээс мэдүүлэг авах” гэж хуульчилж өгснөөр байгууллагуудын статистик тоон мэдээлэлд бүртгэгдсэн хэргийн болон хохирогчийн тоо зөрөх нь цаашид багасна гэж үзэж байна.

2.4.5. Гэмт хэргийн хохирол, хор уршгийг тогтоох, үнэлэх, нөхөн төлүүлэхтэй холбоотой хууль тогтоомжийн зохицуулалтад байгаа хийдэл, давхардал, шүүхийн практикт учирч буй хүндрэл бэрхшээл

Монгол Улсын эрүүгийн эрх зүйн тогтолцоонд сүүлийн жилүүдэд хийгдсэн шинэтгэлийн хүрээнд гэмт хэргийн хохирол, хор уршгийн талаарх уламжлалт ойлголт, хандлагыг өөрчилж, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг тогтоох, тодорхойлох, хохирол, хор уршгийг мөнгөн дүнгээр илэрхийлж нөхөн төлүүлэх талаар материаллаг болон процессын эрх зүйн шинэ орчин бүрдсэн. Гэмт хэргийн хохирол, хор уршгийн талаарх ухагдахууныг хуульд шинээр тодорхойлж, шударга ёсыг сэргээн тогтоох үзэл санаанд суурилсан эрүүгийн хариуцлагын тогтолцоог нэвтрүүлсэн билээ. Харамсалтай нь Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиуд хэрэгжээд даруй 3 жил гаруй болж байхад гэмт хэргийн хохирлыг тогтоох, үнэлэх ажиллагаа одоо ч хуучин арга барилаар явагдаж, хохирол нөхөн төлүүлэх, хохирогчийн эрхийг нөхөн сэргээх явдалд дорвитой ахиц гараагүй таагүй дүр зураг ажиглагдсаар байна.

Тухайлбал, хорих ялтай, хөнгөн гэмт хэрэг үйлдсэн хүний ялыг хорих ял оногдуулахгүйгээр тэнсэж болох боловч хорих ял оногдуулахаар заагаагүй буюу хорихоос өөр төрлийн ялтай гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага заавал хүлээлгэж, ял оногдуулж буй нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “...Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” гэсэн заалтыг зөрчиж, Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлд заасан “Шударга ёсны зарчим”-ыг алдагдуулахад хүргэжээ.

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд хүний биед гэмтэл учруулах гэмт хэргийн талаарх үзэл баримтлалыг өөрчилж биед учирсан гэмтэл болон түүний улмаас үүсэх үр дагаврыг тооцож гэмт хэргийн хохирлыг нөхөн барагдуулах зорилгоор “Эрүүл мэндийн хохирол, хор уршиг” хэмээх хууль зүйн ойлголтыг

бий болгосон. Эрүүгийн хуулийн 11 дүгээр бүлэгт хүний эрүүл мэндэд хохирол учруулах гэмт хэргийн шинжийг тодорхойлсон байдаг. Уг хуулийн үзэл баримтлал, хууль тогтоогчийн анхны үзэл санааг авч үзвэл, эрүүл мэндийн хохирол нь бие махбодын болон сэтгэл санааны гэсэн хоёр хэлбэртэй байхаар тооцоолж, гэмт хэргийн улмаас шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд, хохирол учирснаас үүдэн гарсан үр дагаврыг хор уршигт тооцохоор Эрүүгийн хуулийн 2.5 дугаар зүйлд заажээ. Хэдий тийм ч хүний эрүүл мэндэд хохирол учруулсан хэргүүдийн хохирол, хор уршгийг тогтоож, үнэлж байгаа мөрдөн шалгах ажиллагааны болон шүүхийн практик харилцан адилгүй байна.

Монгол Улсын хувьд гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох асуудлыг Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 132 дугаар тогтоолын хавсралтаар "Зарим төрлийн гэмт хэргийн хохирогчид төрөөс нөхөн төлбөр олгох журам"-ыг баталсан байдаг. Уг журамд зааснаар Эрүүгийн хуулийн зарим төрлийн гэмт хэргүүдийн улмаас амь насаа алдсан этгээдийн гэр бүлийн гишүүн, хүнд гэмтэл учирсан хохирогчид төрөөс нөхөн төлбөр олгох асуудлыг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 10 дугаар зүйлд зааснаар олгохоор зохицуулсан. Төрийн зүгээс олгож байгаа нөхөн төлбөрийн асуудал нь дээрх хохирол нөхөн төлүүлэлтийн харилцааг зохицуулж байгаа болохоос биш хүний амь нас, бие эрхтнийг болон сэтгэл санааны хохирлыг үнэлж байгаа асуудал биш юм. Мөн ялтан болон түүний хууль ёсны төлөөлөгч хохирлыг бүрэн барагдуулсан тохиолдолд улсаас нөхөн төлбөрийг олгохгүй.

Түүнчлэн Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т "Шинжилгээ хийх журмыг шинжилгээ хийх хэлбэр, шинжилгээний төрлөөс хамааран хууль зүйн, эрүүл мэндийн болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална" гэж хуульчилсан боловч Шүүхийн практикт гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг төрөл тус бүрээр нь тооцож, үнэлэх асуудлыг тодорхойлсон журмыг одоог хүртэл батлаагүйн улмаас дээр дурдсан бэрхшээл, асуудлыг үүсгэсэн байна.

ДҮГНЭЛТ

1. Монгол Улсад гэмт хэргийн улмаас хохирогчийн эрхийг хангах чиглэлээр хууль зүйн зохицуулалт шинэчлэгдсэн боловч түүнийг хэрэгжүүлэх арга барил шинэчлэгдээгүй, тодорхой аргачлал, журмуудыг шинээр батлан хэрэгжүүлээгүй, хууль сахиулагчдын хуучин хэвшмэл хандлагаас шалтгаалж гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчийн эрхийг хангах, түүнийг нөхөн сэргээх байдал хангалтгүй байна. Тухайлбал, хууль сахиулагч, прокурорын ажил дүгнэх үзүүлэлт шинэчлэгдээгүй, хохирол, хор уршгийг үнэлэх талаарх хуучин заавар, дүрэм, журам, практик өнөөг хүртэл мөрдөгдсөөр байгаа нь хууль дэвшүүлсэн зорилтдоо хүрэхэд саад учруулсаар байгаа болно.
2. Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн хохирол, хор уршгийг мөнгөн дүнгээр үнэлэн тогтоох практик янз бүрээр тогтож байгаа бөгөөд ихэнх мөрдөгч, прокурор, шүүгч гэмт хэргийн хор уршгийг иргэний гэм хор, 2002 оны ЭБШХ үйлчилж байх үед тогтсон эрүүгийн процесс дахь иргэний нэхэмжлэлтэй андуурах, хольж хутгах зэрэг ойлголтын зөрүү байсаар байгаа нь хуулийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна. Цаашид гэмт хэргийн хохирол, хор уршгийг тогтоох, үнэлэх, барагдуулах талаар мөрдөгч, прокурор, шүүгчийн ур чадварыг сайжруулах, нэгдсэн ойлголтыг сургалтаар олгох шаардлагатай.
3. Судалгааны явцад өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн хохирлыг практикт харилцан адилгүй хэмжээгээр тогтоож буй дур зураг ажиглагдлаа. Хууль тогтоогчийн үзэл санаа, хуулийн төслийн үзэл баримтлалаас үзвэл, хөрөнгийн хохирлыг эд хөрөнгийн болон эдийн бус хөрөнгө гэсэн байдлаар ангилж түүний шинж байдлыг мөрдөн шалгах ажиллагаагаар тогтоож, шүүх үнэлэх замаар хохирол тогтоохоор тусгажээ.

Өнөөгийн байдлаар өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг хэрхэн үнэлэх аргачлал, үнэлгээний журмыг шинэчлээгүйгээс 1992 оны Нийслэлийн АДХ-ын тогтоолоор

баталсан “Эд зүйлийн үнэлгээ” гэсэн хуульд байхгүй ухагдахуун, хуучин байсан аргачлалыг хэрэглэж, шүүх ажиллагааны явцад дээрх байдлаар эд зүйлийг үнэлж тогтоон хэргийг шийдвэрлэж байна. Түүнчлэн мөрдөгч, прокурор, шүүгчийн зүгээс шинэ хуулийн үзэл хандлага, зохицуулалтын цаад учир шалтгаан, арга зүйг ойлгож ухамсарлаагүйгээс хохирол, хор уршгийг үнэлэх ур чадвар, арга зүй өөрчлөгдсөнгүй. Тухайлбал, гэмт хэргийн хохирол, хор уршиг, иргэний эрх зүйн гэм хор гэх мэт ойлголт хоорондын ялгааг төдийлөн сайн мэдэхгүй байх, эрүүгийн хэрэг дэх иргэний нэхэмжлэгч, хариуцагчийн талаарх хуулийн зохицуулалтын шинэлэг агуулгыг сайтар ойлгоогүй болох нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Практикт яг адил нэр төрлийн, ижил үнэтэй эд зүйлийг хэт ялгамжтай байдлаар үнэлж байгаа нь судалгааны явцад ажиглагдлаа. Эд зүйлийг хөрөнгийн үнэлгээний байгууллагууд өөрийн үзэмжээр үнэлж, хохирогчийн үнийн саналаас ихэнхдээ бууруулан үнэлэх эсхүл адил арга замаар хохирол учруулсан гэмт хэрэгт өөр өөр үнийн дүн тогтоож үнэлгээ хийж байгаа нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийг судлах явцад ажиглагдлаа. Хэрэг бүртгэлт, мөрдөн шалгах, шүүхээр хэргийг хянан хэлэлцэх шатанд гэмт хэргийн улмаас учирсан хор уршгийг тодорхойлох ажиллагаа огт хийгдэхгүй байгаа бөгөөд төрийг төлөөлөн оролцож байгаа субъект, хохирогч, иргэний нэхэмжлэгч, тэдгээрийн өмгөөлөгч нар энэ талаар санаачилга гаргадаггүй нь ажиглагдсан болно.

4. Гэмт хэргийн улмаас бусдын сэтгэл санаанд учирсан хохирлыг нөхөн төлж, үнэлж байгаа шүүхийн практик туйлын хангалтгүй байна. Сэтгэл санааны хохирлыг үнэлэх, үнэлгээжүүлэх, тооцох аргачлал, эрх орчин байхгүй учир гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг Эрүүгийн шүүхийн шатанд ч, иргэний нэхэмжлэл гаргах замаар иргэний шүүхийн шатанд ч нөхөн төлүүлэх боломжгүй байна.
5. Монгол Улсын шүүхийн практикт гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг төрөл тус бүрээр нь тооцож, үнэлж чадахгүй байгаа нь

ХЗДХЯ, ЭМЯ, СЯ зэрэг хуулиар үүрэг хүлээсэн байгууллагууд Эрүүгийн хууль тогтоомжийн шинэчлэлийн дараагаар түүний үзэл баримтлал, хуулийн зохицуулалтад нийцсэн бие махбодын, сэтгэл санааны, эдийн болон эдийн бус хөрөнгийг үнэлэх аргачлалыг шинээр батлан гаргаж, хэрэгжүүлээгүйтэй шууд холбоотой.

6. Шүүхийн практикаас харахад эдийн бус хохирлыг мөнгөн хэлбэрээр арилгуулахаар гаргасан нэхэмжлэлийн ихэнхийг нь хэрэгсэхгүй болгох, эсхүл нэхэмжлэлийн шаардлагын хэмжээг эрс багасгаж шийдвэрлэдэг жишиг тогтжээ. Мөн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэмт хэргийн улмаас учирсан хохирлын шинж чанар, хэр хэмжээг нотлох, нэхэмжлэлийг хангах арга хэмжээ авах ажиллагаа төдийлөн хийгддэггүй нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны практикаас харагдаж байна.
7. ХЗҮХ-гээс 2007 онд хийсэн хохирогчийн эрхийн хэрэгжилтийн төлөв байдлын талаарх суурь судалгаанд дурдагдсан үндсэн асуудал, дэвшүүлсэн зөвлөмжүүд шийдвэрлэгдээгүй хэвээр байна.
8. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг төрөөс нөхөн барагдуулах асуудлыг хуульчлан зохицуулаагүй, энэ талын практик байхгүй тул гадаад улсын хууль тогтоомж, практик, олон улсын чиг хандлагыг судлах замаар Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1-д заасан “төр нь хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцах” үүргээ хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Өөрөөр хэлбэл, гэмт хэргийн хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, учирсан хохирол, хор уршгийг шударгаар барагдуулах үндэсний тогтолцоог нэн даруй бүрдүүлэх шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүрлээ.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, гэмт хэргийн улмаас учирсан амь нас, сэтгэл санаа, эрүүл мэнд, эд хөрөнгө, эдийн бус хохирлыг мөнгөн дүнгээр үнэлэх, тооцох аргачлалыг бий болгох шаардлага зүй ёсоор урган гарч байгаа тул хууль тогтоомж, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгохыг цаг үе шаардаж байна.
2. Эрүүгийн хууль тогтоомжийн шинэтгэлд нийцүүлэн гэмт хэргийн хохирол, хор уршгийг тогтоох, үнэлэх, нөхөн барагдуулах суурь тогтолцоо бүрдүүлэх шаардлагатай байна. Тухайлбал, Монгол Улсад гэмт хэргийн хохирол нөхөн барагдуулах үндэсний тогтолцоог бий болгох асуудлыг Хохирлын сангийн тухай хууль бусад хууль тогтоомжтой уялдуулах шаардлагатай. Энэ хүрээнд гэмт хэрэг, зөрчлийн торгууль, хүүгийн орлого орон нутгийн төсвийн бус орлогод төвлөрч байгааг өөрчилж, хохирлын сан бий болгох, энэ сангаар дамжуулан гэмт хэргийн хохирогчид нөхөх олговор олгох тухай зохицуулалт хийх боломжтой.
3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу гэмт хэргийн улмаас эд хөрөнгөд учирсан хохирлыг шинжээчээр тогтоолгох заалтыг хэрэгжүүлэх, шинжээчийн гэмт хэргийн хохирлыг тогтоохдоо эд зүйлийн шинж байдал, үнэлгээ хийх ур чадварыг нэмэгдүүлэх нь зүйтэй. Мөн мөрдөгч, прокурор, шүүгчийн хуулиар олгосон эрх, үүргийн хүрээнд тухайн эд зүйлийн шинж байдлыг тогтоох замаар мөрдөн шалгах ажиллагааны тодорхой хэлбэрийг ашиглан хохирол, хор уршгийг тогтоох ур чадвар, арга зүйд сургах шаардлагатай.
4. Эрүүгийн хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нийцүүлэн гэмт хэргийн улмаас бие махбод, сэтгэл санаанд учирсан хохирлын үнэлгээний заавар журам, аргачлалыг шинээр боловсруулж хэрэгжүүлэх. Мөн үүний тулд Эрүүгийн хуулийн үзэл баримтлалд нийцсэн, хүний бие

махбод, эд эрхтний үнэлгээг бий болгох нь зүйтэй. Тухайлбал, Оросын Холбооны Улсад сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийг шүүхийн журмаар олгож, нөхөн төлбөр олгохдоо тухайн гэм буруутай үйлдлийг хийсэн этгээдээс нэхэмжлэлийг гаргуулж, эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэхэд Иргэний хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон Эрделевскийн хүснэгтийг ашигладаг байна.

5. Бусад улс орны сайн жишгийг судлах замаар сэтгэл санааны хохирлыг тооцож үнэлэх, нөхөн олгох эрх зүйн орчин, практикийг бий болгох шаардлагатай. Тухайлбал, шүүх эмнэлгийг, сэтгэц гэм судлалын шинжлэх ухаантай хослуулан хөгжүүлж хүний сэтгэл санааны хохирол тооцох аргачлалыг гаргах, хэрэгжүүлэх шаардлагатай байна.
6. Гэмт хэргийн хор уршгийг үнэлэх илтгэлцүүр, жишиг гарган мөрдүүлэх. Тухайлбал, хүний эрүүл мэндэд хохирол учруулсан хэргүүдийн хувьд гоо сайхныг алдагдуулсан байдал, эмчилгээ хийлгэсэн хугацаа, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ (өөрөө явж чадахааргүй асаргаа сувилгаа шаарддаг болсон, хөгжлийн бэрхшээлтэй болсон гэх мэт) зэрэг шалгуур үзүүлэлтийг харгалзан үзэх нь зүйтэй.
7. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээг зөв тогтоох, бодит үнэлгээг гаргуулах, нөхөн төлөлтийг баталгаатай болгох зорилгоор, хөрөнгө битүүмжлэх, хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хянах, хязгаарлах ажиллагааг мөрдөн шалгах явцад өргөн хэрэглэх хэрэгтэй.
8. Цаашид олон улсын сэтгэцийн өвчний ангилалд нийцүүлсэн сэтгэл зүйн хохирол, хор уршгийг тооцох аргачлал, эдийн болон эдийн бус хөрөнгийг үнэлэх (биет болон биет бус) жишиг аргачлал батлах нь зүйтэй.
9. Эрүүгийн хэрэгт гэмт хэргийн хор уршгийг иргэний хэргийн гэм хортой андуурч тусад нь шийдвэрлэхээр дурдаж шийдвэрлэж байгаа шүүхийн практикийг халах, үүний тулд хуульч, хууль сахиулагчдын энэ талаарх мэдлэг ойлголтыг дээшлүүлэх шаардлагатай.

НОМ ЗҮЙ

1. “Монгол Улс дах Гэмт хэргийн цагаан ном” 2016 он, 2017 он, 2018 он. ГХУСАЗЗ
2. “Судалгааны тайлангийн 1, 2 эмхэтгэл”. 2019 он. УЕПГ
3. Эрүүгийн процессын эрх зүйн үндсэн асуудал УБ 2018, Ж.Бямбаа, Ж.Эрхэсхулан
4. “Хүний эрхийн товч тайлбар”, УБ 2015 он. Монгол Улсын ХЭҮК
5. “Шударгаар шүүлгэх эрх”, УБ 2014 он. Эмнести интернэшнл Олон улсын байгууллага
6. Б.Чимид. “Үндсэн хуулийн үзэл баримтлал: Нийтлэг үндэслэл, Хүний эрх, шүүх эрх мэдэл, Нутгийн удирдлага”, Улаанбаатар хот., 2017 он
7. “Хүний халдашгүй эрх”, Х.Эрдэнэбат. УБ, 2002 он
8. Хууль зүйн үндэсний хүрээлэн. “Гэмт хэргийн улмаас учирсан хохирол”, Улаанбаатар хот., 2007 он
9. “Хүний эрх ба эрүү шүүлт”, П.Оюунчимэг. 2009 он.
10. Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрүүгийн эрх зүй, криминологийн сектор. “Хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн хүмүүсийн сэтгэл зүйн хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тогтоох нь” судалгааны тайлан, 2009 он
11. Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он, Төрийн мэдээлэл эмхэтгэл №1
12. Эрүүгийн хууль, (Шинэчилсэн найруулга), 2016 он, Төрийн мэдээлэл эмхэтгэл №7
13. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (Шинэчилсэн найруулга), 2017 он, Төрийн мэдээлэл эмхэтгэл №23
14. “Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль” сургагч багшийн гарын авлага, 2017 он, ХЗДХЯ
15. “Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэглээ”, Б.Гантулгабат. 2019 он

ISBN 991996781-5



9 789919 967819